

ШУТИС-ИЙН БАГШ ПРОФЕССОРУУДЫН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ ХИЙГДСЭН ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТУУД

| Д/д | Улсын бүртгэлийн дугаар | Шинэ бүтээлийн нэр | Зохиогч, хамтран зохиогч | Олон улсын ангилал | Патент эзэмшигч | Анхдагч огноо | Давамгайлах огноо | Шинэ бүтээлийн томъёолол |
|-----|-------------------------|--|---|--------------------|---|----------------|-------------------|---|
| 1. | 0083 | Чацарганы хөлдүү жимс хураах машин /ЧХДМ-2/ | Ч.Авдай Кошевников Г.А. Б.Сүрэнхор Осипов Ю.С. | , | Ч.Авдай, Кошевников Г.А, Б.Сүрэнхор, Осипов Ю.С. | 1975.03.14. | 1975.04.29. | Чацарганы хөлдүү жимс хураах машин нь арал, зөөлөвчтэй саваа бүхий хос босоо самбар, хүч авах голтой холбогдсон доргиур хүрд, телескоп механизм, туузан дамжуулга, тээвэрлэх тэргэнцэр зэргээс бүрдсэн бөгөөд бутлаг модны жимс хураах машинаас үндсэн ялгаа нь чацарганы хөлдүү жимс хураах гар ажиллагааг механикжуулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хийцийг хялбарчлах зорилгоор доргиурыг гидромотортой холбон тракторт хэд хэдэн машин угсрах боломжтой болгож, мөчрийн байршлаас хамааруулан доргиох савааны байршлыг өөрчлөх боломжтой болгосонд оршино. |
| 2. | 0084 | Чацарганы жимс соруулж хураах Машин /ЧХХМ-1/ | Ч.Авдай Кошевников Г.А Н.Төмөрбаатар | , | Ч.Авдай, Кошевников Г.А, Н.Төмөрбаатар | 1975.03.14. | 1975.04.29. | Өндөр даралтын вакуум хөөрөг /насос/-тэй холбогдсон хэрэггүй хольц хадгалах тэвш, сорох хоолой, жимсийг мөчрөөс нь салгах хоолой ба салхин сэнс, жимсний тэвш, зөөгүүр тэргэнцэр зэргээс бүрдсэн жимс соруулж хураах машины гар ажиллагааг механикжуулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, модны гэмтэл ба жимсний хаягдлыг багасгах зорилгоор шинээр зохиомжилсонд оршино. |
| 3. | 209 | Барьцал дуулагч материал | Б.Батцагаан | , | Б.Батцагаан | 1981. 02.28 | 1981. 09.07. | Орон нутгийн эрдэс түүхий эдээр ус чийгтэй орчинд бэхжих чадвартай цементийг орлох хольмог барьцалдуулагч материал юм. |

| | | | | | | | | |
|----|-----|--|--|---|--|----------------|-----------------|---|
| 4. | 234 | Өнгөт тоосго шатаах хонгил камерийн зуух | Ц.Жадамбаа, Нехорошев Алексей Васильевич | , | Ц.Жадамбаа, Нехорошев Алексей Васильевич | 1981. 05.01 | 1982. 11.22. | Өнгөт тоосго шатаах хонгил камерийн зуух нь шатаалтын явцад хийн орчныг бүрэн жолоодох боломжтой. |
| 5. | 235 | Өнгөлгөө ний өнгөт тоосго үйлдвэрлэх арга | Ц.Жадамбаа, Нехорошев Алексей Васильевич | , | Ц.Жадамбаа, Нехорошев Алексей Васильевич | 1981. 05.01 | 1982. 11.22. | Ердийн тоосгоны амархан хайламтгай шавраар хийсэн тоосгыг жолоодлоготой уур хийн орчинд шатааж өнгөлгөөний өнгөт тоосго гарган авахад уг аргын шинэлэг тал оршино. |
| 6. | 236 | Хөнгөн тоосгыг үртсэн нэмэлттэй үйлдвэрлэх арга | Ц.Жадамбаа | , | Ц.Жадамбаа | 1981.05.01. | 1982.11.22. | Ердийн тоосгоны түүхий эдийг тодорхой ширхэглэлтэй үртсэн нэмэлттэйгээр үйлдвэрлэж 75-с доошгүй марктай хөнгөн тоосго үйлдвэрлэх зорилготой. |
| 7. | 237 | Өнгөлгөө ний ба хөнгөн тоосгон угсармал хавтгайлж бэлтгэх арга | Ц.Жадамбаа | , | Ц.Жадамбаа | 1981.05.01. | 1982.11.22. | Шатамхай нэмэлттэй хөнгөн болон өнгөлгөөний тоосгоор угсармал хавтгайлж үйлдвэрлэх технологийн аргын шинэлэг тал нь тоосгон барилгын ханыг үйлдвэрийн аргаар гүйцэтгэхэд оршино. |
| 8. | 356 | Эмийн ширхэг жүүлсэн бүтээгдэхүүнийг псевдо шингэрсэн давхаргад хатаах төхөөрөмж | Ж.Цэен-Ойдов Ц.Шагдарсүрэн Х.Энхжаргал С.Батмөнх Ч.Даваасамбуу Б.Намхайнням | , | Ж.Цэен-Ойдов Ц.Шагдарсүрэн Х.Энхжаргал С.Батмөнх Ч.Даваасамбуу Б.Намхайнням | 1984.11.30 | 1986.02.08. | Эмийн ширхэгжүүлсэн бүтээгдэхүүнийг псевдо шингэрсэн давхаргад хатаах төхөөрөмжийн ялгаа нь эмийг ширхэгжүүлсэн бүтээгдэхүүн хатаах зориулалттай конус хэлбэрийн халаалгын хорго, агаар хуваарилах тор зэргээс бүрдэх бөгөөд хэвтээ иэнхлэгт эргэж онгойх хийцтэй төхөөрөмж юм. |

| | | | | | | | | |
|-----|-----|---|--|---|--|-------------|-------------|---|
| 9. | 358 | Чацаргана цэвэрлэх төхөөрөмж | Ч.Авдай Б.Балган | , | Ч.Авдай Б.Балган | 1985.03.13. | 1986.02.13. | Гурван төрлийн шигшүүр, салхин сэнс, тахир гол-шатуны механизм зэрэг ажлын хэсгээс бүрдсэн чацаргана цэвэрлэх машины ялгаа нь чацаргана цэвэрлэх ажиллагааг механикжуулж, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 3 шигшүүрийг нэг гол дээр хэвтээ чиглэлд зэрэгцээ байрлуулж дээд шигшүүрт чацарганаас мөчир, навч, бусад томоохон хольцыг дунд шигшүүр дээр мөчрөөс чацарганыг, тэдгээрээс жижиг хэсгийг төгсгөлийн шигшүүрээр тус тус ялгаж авахаар зохиомжилсонд оршино. |
| 10. | 446 | Чацарганы тос гаргаж авах арга | Ч.Авдай Г.Баасанхүү Б.Сүрэнхор Ч.Туул Г.Чимэд-Очир | , | Политехникийн дээд сургууль | 1988.02.01. | 1988.07.14. | Чацарганы шахдасаас ялгасан хуурай хальсыг ургамлын тосоор экстракт давтан хийх замаар чацарганы тос гаргаж авах аргын ялгаа нь тосны биоидэвхит бодис каротины агуулгыг нэмэгдүүлэх, экстракцлах процессыг хурдасгах, диффузорын тоог цөөлөх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилготой. Энэхүү аргын үед чацарганы тосоор бүрэн баяжсан ба баяжаагүй, эсхүл бага баяжсан ургамлын тосууд хоорондоо холилдохгүй болсноос нэгэнт баяжсан тосны баяжилтын зэрэг буурах дутагдал арилж эцсийн диффузороос 180-200мг % каротиноид агуулсан тосыг гаргаж авав. |
| 11. | 474 | Шавьж сорж цуглуулж, боловсруулах төхөөрөмж | Ч.Авдай Ш.Батмөнх В.Ганбаатар Ц.Дашдорж Н.Зоригт В.Цэдэн-Иш | , | Ч.Авдай Ш.Батмөнх В.Ганбаатар Ц.Дашдорж Н.Зоригт В.Цэдэн-Иш | 1988.04.30 | 1989.04.17. | Цахилаан үүсгүүр, сэнс, вакуум сав, дамжуулах хоолой, сорох хошуу, тогоо зэргээс бүрдэх шавьж сорж цуглуулж, боловсруулах төхөөрөмжийн ялгаа нь шавьжийг сорж цуглуулан боловсруулж, уурагт тэжээл бэлтгэх зорилгоор автомашины жигд явалтанд сорох сэнсний тусламжийгаар нисдэг шавьжийг хөөрөлт, дэхрэлт дунд нь тогтоон барьж цуглуулах сав руу сорж оруулан, дотор нь хольж хэрчинэ. Эргэлдэх хутга бүхий халуун усан цамцтай тогоонд царцаа дэвхрэгнийхээ жижиглэсэн холимгийг юүлж хатаагаад нунтаглаж боловсруулна. |

| | | | | | | | | |
|-----|-----|------------------------------------|--|---|--|-------------|-------------|--|
| 12. | 482 | Чацарганы тос ялгаж авах төхөөрөмж | Ч.Авдай С.Бат Г.Чимэд-Очир Б.Сүрэнхор Ч.Норовсамбуу Ч.Нацагдорж | , | Ч.Авдай С.Бат Г.Чимэд-Очир Б.Сүрэнхор Ч.Норовсамбуу Ч.Нацагдорж | 1989.02.20. | 1989.09.01. | <p>Чацарганы тос ялгаж авах төхөөрөмжийн ялгаа нь хандлалтыг эрчимжүүлэх, чанарыг сайжруулах зорилгоор усны нэгдсэн цамцанд тоногдсон диффузоруудад шингэний эсэргүүцлийг бууруулах торон тавиуруудын хооронд чихсэн чацарганы жимсний зөөлөн эд, хальсыг хандлах ургамлын тосоор дүүргээд 2 цаг тутамд хандлаганы шингэн тосыг хооронд нь холихгүйгээр цахилгаан соронзон удирдлагатай буцаах хавхлагаар дамжуулан дараагийн диффузоруудад шилжүүлэн шахах замаар ханасан ханд /баяжсан тос/ үүссэний дараа цэвэр хальсаар шүүж тос ялгаж авах угсраа дамжлагыг алсын удирдлагад холбосонд оршино.</p> <p>Энэхүү шинэ бүтээлийн дагуу төхөөрөмжийг зохион бүтээж, 1983 онд Улаанбаатар хотын эмийн завод, 1985 онд Сэлэнгэ, 1986 онд Завхан аймгийн эмийн сангуудыг удирдах газар, 1988 онд Дарханы Шарын голын жимс ногоо, консервийн үйлдвэр, 1990-1992 онд Увс аймгийн чацаргана боловсруулах үйлдвэр, ХААЭШС-ний станц, Чацарганы аж ахуйд тус тус төхөөрөмж хийж өгсөний зонхилох нь одоо тос үйлдвэрлэсээр байна.</p> |
| 13. | 547 | Хадуурын хутга ирлэх төхөөрөмж | Ч.Авдай Ч.Батхүрэл Ж.Гомбосүрэн Б.Сүрэнхор Т.Жавчивдорж | , | Ч.Авдай Ч.Батхүрэл Ж.Гомбосүрэн Б.Сүрэнхор Т.Жавчивдорж | 1990.06.07. | 1991.03.06. | <p>Их бие хөдөлгүүр, ирлэгээний дугуй, баригч, хөргөх системээс бүрдэх хадуурын хутга ирлэх төхөөрөмжийн ялгаа нь ирлэлтийн чанарыг сайжруулж, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор шингэнээр хөргөж, хэвтээ байрлалд эргэх дугуйд ирлэх хутгыг шатлуулан давхарлаж, хавчин баригчийг хуваарьтай нугас, ирлэгээг хязгаарлагч бүхий дугуйн элэгдэлтээр сунах шилбэтэй зохиомжилсонд оршино.</p> |
| 14. | 559 | Вааран эдлэлийн цайвар хольцын жор | Ц.Жадамбаа | , | Төв аймгийн урчуудын эвлэлийн салбарт | 1991.02.21. | 1991.03.16. | <p>Вааран эдлэлийн цайвар өнгийн нягт керамик биетийг орон нутгийн болон хаягдал /шил/ ашиглан гарган авахад уг аргын шинэлэг тал оршино.</p> |
| 15. | 560 | Вааран эдлэлийн өнгөт хольцын жор | Ц.Жадамбаа | , | Төв аймгийн урчуудын эвлэлийн салбарт | 1991.02.21. | 1991.03.16. | <p>Вааран эдлэлийн өнгөт керамик массыг орон нутгийн түүхий эд болон хаягдал /шил/ ашиглан гарган авахад уг аргын шинэлэг тал оршино.</p> |

| | | | | | | | | |
|-----|-----|-------------------------------------|-------------------------------------|--------------------|---------------------------------------|-------------|-------------------------|--|
| 16. | 561 | Вааран эдлэлийн паалангийн жор | Ц.Жадамбаа С.Шаарийхүү | . | Төв аймгийн урчуудын эвлэлийн салбарт | 1991.02.21. | 1991.03.16. | Нам температур /1000°C/-т хайлдаг нэг удаагийн хайлалтаар /фриттлээгүй/ паалан гарган авах жор тогтоосонд уг аргын шинэлэг тал оршино. |
| 17. | 597 | Эмнэлгийн гөлтгөнө гаргаж авах арга | Б.Батцагаан С.Загдсүрэн | . | Б.Батцагаан С.Загдсүрэн | 1991.05.22. | 1991.07.06. | Байгалийн хоёр уст цэвэр гөлтгөний жоншоор 1.2атм даралтын орчинд α дүрсийн ус шаардалт багатай, хүний биед сөрөг нөлөө үзүүлэхгүй, өндөр бат бэхтэй барьцалдуулагч гарган авахад оршино. |
| 18. | 687 | Жимс сорж хураах тосгуурт төхөөрөмж | Ч.Авдай Б.Балган А.Мягмар | МКИ А01 Д 46/26 | Техникийн их сургуульд | 1992.02.02. | 1992.05.22. | Вакуум насос, сорох хошуунаас бүрдэх жимс сорж хураах төхөөрөмжийн ялгаа нь хийцийг хялбарчлах, бүтээлийг ахиулах зорилгоор вакуум хураагуурын сорох хошуунд самнуур нэмж угсарсанд оршино. |
| 19. | 688 | Жимс хураах тосгуурт төхөөрөмж | Ч.Авдай Б.Балган | МКИ А 01 Д 46/22 | Техникийн их сургуульд | 1992.02.22. | 1992.05.22. /15 жил/ | Пүрштэй далбаа чиглүүлэгч, тулгуураас бүрдэх Жимс хураах тосгуурт төхөөрөмжийн ялгаа нь хаягдлыг багасгах зорилгоор хэвтээ хавтгайд 20-30 градус үүсгэх тосгуурын далбааг анхны байрлалд нь барихаар түүнд бэхлэгдсэн пүрштэй холбосон чиглүүлэгчийг тулгуурт хөдөлгөөнгүй бэхэлсэн. |

| | | | | | | | | |
|-----|-----|---|--|---------------|--|-------------|-------------|--|
| 20. | 745 | Цохилтын долгионоор бодис боловсруулах хэрэгсэл | О.Цэвэлсүрэн Ц.Очир Б.Цэвэгдорж | /4/ В 01 3/08 | О.Цэвэлсүрэн Ц.Очир Б.Цэвэгдорж | 1992.05.08. | 1992.10.22. | Цохилтын долгионоор бодис боловсруулах хэрэгслийн ялгаа нь бат бэх чанарыг дээшлүүлэх зорилгоор 8-10мм голчоор цоолсон 50-55мм зузаан 300мм-ээс багагүй голчтой ган цулыг сууринд хөдөлгөөнгүй бэхэлсэн. |
| 21. | 752 | Бал чулуу боловсруулах арга | Б.Цэвэгжав О.Цэвэлсүрэн Ц.Очир | . | Б.Цэвэгжав О.Цэвэлсүрэн Ц.Очир | 1992.05.08. | 1992.12.05. | Бал чулуу боловсруулах аргын ялгаа нь оронт торыг өөрчлөх зорилгоор ган бортгонд чигжсэн бал чулуунд 2-3мм-ийн зузаан хөнгөн цагаан хаалтаар дамжуулан тэсрэлтийн $1.8-2.0 \cdot 10^5 \text{кг/см}^2$ цохих долгионоор үйлчлүлсэн. |
| 22. | 780 | Усан халаалтын тогоо | Ж.Цэен-Ойдов Т.Отгонбаяр С.Батмөнх | 5 F 24 Н 1/00 | Ж.Цэен-Ойдов Т.Отгонбаяр С.Батмөнх | 1992.11.11. | 1993.02.05. | 1. Галын хотол, утааны сувгаас бүрдэх Усан халаалтын тогооны ялгаа нь дулаан солилцоог эрчимжүүлэх, АҮК-ийг дээшлүүлэх зорилгоор цацрагийн халаах гадаргуугийн хоорондох галын хотлын дээд хэсэгт хэвтээ хавтгайд 25 градусын налуугаар байрлах, шатрын байрлалтай хоолойнуудын төгсгөлийг эсрэг чиглэлд матаж ар өврийн хаалтыг үүсгэсэн. 2. Халаалтын тогооны нэгдүгээрийн ялгаа нь галын хотлоос гарах утааны сувагт угсарсан урсгалын дулаан солилцох /конвектив/ гадаргууг хотлын хажуугийн гадаргуутай солбиулж холбосон. |
| 23. | 829 | Тэсрэх хольц бэлтгэх арга | Б.Лайхансүрэн Г.Пүрэвсүрэн Г.Тулга Ц.Энхболд Т.Батжаргал Х.Жаргалсайхан | 5С 06 В 31/30 | Б.Лайхансүрэн Г.Пүрэвсүрэн Г.Тулга Ц.Энхболд Т.Батжаргал Х.Жаргал сайхан | 1993.03.01. | 1993.08.07. | Тэсрэх хольц бэлтгэх аргын ялгаа нь энгийн тэсрэх бодисын бүрэлдэхүүн хэсэг аммиакийн шүү, дизелийн түлшин дээр битум болон бусад шатах ба барьцалдуулагч нэмэгдлийг нэмж бэлтгэсэнд оршино. |

| | | | | | | | | |
|-----|------|--|---|---------------------|---|-------------|-------------|--|
| 24. | 852 | Хэвний гөлтгөнө бэлтгэх арга | Б.Батцагаан П.Болорчулуун Д.Сэдэд | 5 С 01 F 11/46 | Дорноговь аймгийн “Баянбогд” компанийн “Тоосго шохойн” үйлдвэрт | 1193.10.11. | 1994.04.26. | Хэвний гөлтгөнө гарган авах аргын ялгаа нь ус шингээх, хий нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх чадварыг дээшлүүлэх, сийрэг талст үүсгэх зорилгоор гөлтгөний чулууг /Ca O ₄ 2H ₂ O/ эрдэсжүүлэгч нэмэлттэй жингийн 1:0.15 харьцаагаар хольж 5-6 цагийн туршид 650-700 хэм халуун хийн үлээлгэн дор 3500см ² /г хувийн гадаргуутай болтол нунтаглан хатааж 160-250 хэмд хуурч хагас уст гөлтгөнө /Ca O ₄ S H ₂ O/ гаргана. |
| 25. | 905 | Нэрэх аппарат | Ч.Авдай Н.Амгалан баатар, Б.Сүрэнхор Х.Нямсамбуу О.Чимэд | - | “Тахилт” ХЭАА | 1994.02.18. | 1994.10.22. | Дан болон нэрлэгийн босоо багана, тавагаас бүрдэх Нэрэх аппаратын ялгаа нь жигдрүүлэх, спиртийн гарцыг нэмэгдүүлэх зорилгоор цагирган бэхэлгээнд тогтоосон тавагнуудын хоорондох босоо зайг зэвэрдэггүй металл зоргодсоор дүүргэсэнд оршино. |
| 26. | 1059 | Шорооноос алт ялгах арга | Б.Алтантуяа Б.Ганболд Д.Дэлэг | 5 С 22 В 5/02, 3/02 | Б.Алтантуяа Б.Ганболд Д.Дэлэг | 1995.06.08. | 1995.11.23. | Шорооноос алт ялгах аргын ялгаа нь алтны гарцыг нэмэгдүүлэх, хөдөлмөр хөнгөвчлөх зорилгоор 0.6-2.0мм хэмжээний бүхлэгтэй алтны “хан” баяжмалыг үрлэн тээрэмд нунтаглаж нэг эгнээт ангилагчид 8.7-21.4м/с хурдтай агаараар, 0.6мм-ээс бага бүхлэгтэй баяжмалыг олон эгнээт ангилагчид 2.8-8.7м/с хурдтай агаараар тус тус үлээлгэн алтыг суулгаж ялгана. |
| 27. | 1200 | Угаалгын шингэн саван гаргаж авах арга | Ч.Авдай Т.Туул Гребенюк М.Н. Терегеря В.В. Перов А.А | 6 С 11 Д 17/08 | “Эврика” ХК | 1996.08.09. | 1997.07.07. | Тослог түүхий эдийг холих, халаах замаар Угаалгын шингэн саван гаргаж авах аргын ялгаа нь технологи ажиллагааг хялбарчлах, түүхий эдийн орцыг багасгах зорилгоор тарваганы тосыг Ингредиент В уусмалтай 1:1 харьцаагаар хольж 90-120°С хэмд халаан 1 цаг хутгаад жингийн 1-2 хувиар кальцжуулсан содыг нэмж хутган саванжуулна. |

| | | | | | | | | |
|-----|------|------------------------------------|--|--------------------|--|-------------|-------------|--|
| 28. | 1281 | “Сандовит” шүүс бэлтгэх арга | Ч.Авдай Э.Долгормаа Ч.Цэнд-Аюуш Г.Одгэрэл | 6А 23 L 2/00, 2/02 | Ч.Авдай Э.Долгормаа Ч.Цэнд-Аюуш Г.Одгэрэл | 1997.04.16. | 1997.12.02. | Няцлах, шүүх, найруулах, тунгалагжуулах замаар “Сандовит” шүүс бэлтгэх аргын ялгаа нь амт чанарыг сайжруулах, хадгалалтын хугацааг уртасгах зорилгоор чацарганы тосгүй цэвэр шүүсийг дараахь хольцтой 80-85°C хэмд 10-15 минут халаана. 100 л шүүсэнд: Чацарганы тосгүй шүүс 45-50л Жүржний ханд 20кг Нимбэгний хүчил 2кг Витамин “961” 0.3кг Витамин “988” 0.2кг Элсэн чихэр 110-120кг Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь тосгүй цэвэр шүүсийг 40-45°C хэмд халааж няцалсан жимсний шүүсийг 2-3 удаа шүүж тунгалагжуулаад 65-70°C хэмд халаан буцалмал усанд хийж, хөргөж бэлтгэнэ. |
| 29. | 1296 | Хуурай аргаар ангилагч | Б.Алтантуяа Г.Баянмөнх Д.Дэлэг | 6 В 07 В 1/02 | Б.Алтантуяа Г.Баянмөнх Д.Дэлэг | 1997.03.10. | 1997.12.25. | Их бие, агаарын хурд тохируулах ялтас, конусан ялтас, оруулах цорго агаар сорох төхөөрөмж, циклоноос бүрдэх Хуурай аргаар ангилагчийн ялгаа нь ангилалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор конусан ялтсыг хананаас $d_{max} < C < 0.04 Da$ зайд тусгаарлан хөндлөвчөөр бэхэлнэ. Төхөөрөмжийн томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь хананд завсаргүй угсрагдсан огтлогдсон конусан ялтсын гадар хүрээнд босоо тэнхлэгийн дагууд $d_{max} < C < 0.04 Da$ хэмжээтэй завсар ухаж гаргана. d_{max} -түүхий эдийн ширхэгийн дээд хэмжээ Da- их биеийн голч |
| 30. | 1297 | Улаан буудайн үр хөврөл ялгах арга | Б.Алтантуяа Г.Баянмөнх Д.Дэлэг | 6 В 07 В 1/04 | Б.Алтантуяа Г.Баянмөнх Д.Дэлэг | 1997.03.10. | 1997.12.25. | Хальслах, ялгах үйлдлээр Улаан буудайн үр хөврөл ялгах аргын ялгаа нь цэвэршилтийн түвшинг дээшлүүлэх зорилгоор ялган ангилагчаас гарсан, хольцтой үр хөврөлийг няцлагч булаар дамжуулж чөлөөт уналтын шатлан ангилагчид 3.1-3.8м/сек хурдтай агаарын урсгалаар цэвэрлээд 1х1мм сүвтэй шигшүүрээр шигшинэ. |

| | | | | | | | | |
|-----|------|--|---|---------------|---|-------------|-------------|---|
| 31. | 1298 | Хуурай аргаар ангилагч | Б.Алтантуяа Г.Баянмөнх Д.Дэлэг | 6 В 07 В 1/04 | Б.Алтантуяа Г.Баянмөнх Д.Дэлэг | 1997.03.10. | 1997.12.25. | Босоо хонгилоос бүрдэх их бие, тэдгээрт бэхэлсэн тараах ялтсууд, оруулах цорго, агаар сорох төхөөрөмж, ул торноос бүрдэх Хуурай аргаар ангилагчийн ялгаа нь ангилалтын түвшинг дээшлүүлэх зорилгоор ангилагчийн эгнээний дунд хэсэгт түүхий эд оруулах цорго болон босоо хонгилын өргөнтэй тэнцүү алхамтай шурган цацагчийг байрлуулсан. |
| 32. | 1509 | Ус цэнгэгжүүлэх арга | Ц.Алтансүвд Т.Лодой Ш.Бямбаа | 6 С 02 F 1/18 | Ц.Алтансүвд Т.Лодой Ш.Бямбаа | 1998.12.07. | 1999.06.03. | Усыг буцалтал халааж ууршуулаад хүйтэн усаар хөлөргөн нэрэх замаар Ус цэнгэгжүүлэх аргын ялгаа нь технологийг хялбарчлах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ус буцалгагч “коллектор-тогоо”-г ердийн ахуйн зууханд байрлуудаад халуун усны хуримтлуурын орох шугаманд термостат суурилуулж, хүйтэн усны савтай холбосон хөргүүрийг төвшин тохируулагчаар тоноглов. |
| 33. | 1604 | Далд уурхайд хүдэр бутлах тэсэлгээний арга | Х.БадамсүрэнЮ. А.Чертков В.А.Тюрин А.А.Лисенко,... | 6Е21С47/00 | Б.Лайхансүрэн В.В.Михайлов Д.Тэгшээ | 1999.06.25. | 1999.12.06. | Мөрөгцгийн цулд нүх өрөмдөх, цэнэглэх, тэслэх замаар Далд уурхайн хүдэр бутлах тэсэлгээний аргын ялгаа нь хүдрийн хэт бутралт, овор хэтэрсэн хэсгийн гарцыг багасгаж жигд бутлах зорилгоор цулын 75-80°-ын налуу мөрөгцөгт завсрын штрекүүд нэвтэрч, нэвирэлтийн завсрын штрекээс тэсэлгээний нүхийг дээш, доош нь угталцах чиглэлээр цацраг байдлаар давхар үеэр сөөлжүүлэн өрөмдөж, дундах штрекээс эхлэн цэнэглэж, үеүдийг хооронд нь хоромын удаашралтай тэслэнэ. |

| | | | | | | | | |
|-----|------|--|--|---------------------|---------------------------|-------------|-------------|---|
| 34. | 1612 | Хялгас ялгах төхөөрөмж | Ш.Баасансүрэн | | Ш.Баасансүрэн | 1999.06.24. | 2000.02.09. | <p>Энэхүү төхөөрөмж нь аж үйлдвэрлэлийн салбарт хамаарах бөгөөд ноолууранд боловсруулалт хийх үйлдвэрт болон анхан шатны боловсруулалтын хялгас ялгах ажиллагаанд ашиглагдана.</p> <p>Уг төхөөрөмж нь их бие, агаар сорох хоолой, вентилятор, ялгах элемент, ноолуур унах цорго зэргээс бүрдэнэ. Хялгас ялгах аппаратын үр ашгийг дээшлүүлэхийн тулд түүнд үүсэх агаарын жигд урсгалд нөлөөлөл бий болгож ноолууран ширхэгтийн эрчинд орсон хялгасны инерцийг алдагдуулах зорилгоор ялгах элемент байрлуулан шатлан ялгах зарчимд оруулна. Энэ ялгах элемент нь конфузын зарчимд үндэслэнэ. Ялгах элементүүдийн хэмжээс, байрлалыг Оргилуур /биетээс цацран садарч гарах агаарын урсгал / үүсгэх зарчимд үндэслэн тогтоох ба эдгээрийн босоогийн дагуух зайг ноолууран ширхэгтийн уртаас 3 дахин их байхаар тооцож өөрөөр хэлбэл хөвөх хурдны хэмжээг жигдрүүлэх зайг тооцон тогтооно. Энэ агаарын урсгалын садралт, цацралтын үед биеийн амсар орчим орчим агаарын урсгалгүй хэсэг үүсдэг. Энэхүү процесс нь агаарын урсгалын нөлөөллийг үүсгэж ялгалт дээшилнэ.</p> |
| 35. | 1681 | “Мөнгөжүүлсэн “Монхангай” архи үйлдвэрлэх арга | Ч.Авдай Б.Сүрэнхор Б.Палам Ц.Цэен Ш.Чулуун баатар | С 12 G 03/12, 03/08 | Монхангай гэрээт диллер-т | 1999.11.08. | 2000.05.30. | <p>1. Мөнгөжүүлсэн “Монхангай” архи үйлдвэрлэх аргын ялгаа нь чанарыг сайжруулах зорилгоор дахин нэрж цэвэршүүлсэн хүнсний спиртийг найрлагын ганд хийж дээрээс нь урьдчилан зөөлрүүлж мөнгөжүүлсэн ус нэмж холиод барилтын ганд шилжүүлэн хоёроос доошгүй цаг амраасны дараа идэвхжүүлсэн цеолит ба нүүрсэн шүүлтүүрээр дамжуулан шүүгээд кварцын элс буюу хадан цагаан элементэн шүүгчээр 30-60л/цаг хурдтай нэвтрүүлэн тунгалагжуулсаны төгсгөлд чихрийн уусмал нэмж сайтар холино.</p> <p>2. Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь шүүж тунгалагжуулсан бүтээгдэхүүнийг контактын аргаар хоёр шаталсан колонк ашиглан мөнгөжүүлэх бөгөөд архинд мөнгөний ионыг 0.2мг/л болтол шингээнэ.</p> |

| | | | | | | | | |
|-----|------|--|---|--------------------------------|---|-------------|-------------|--|
| 36. | 1682 | Хивсний зориулалтын ээрмэл үйлдвэрлэх арга | Г.Надмид Д.Мөнхжаргал А.Батсайхан | 6 D 01 H 4/08 | Г.Надмид Д.Мөнхжаргал А.Батсайхан | 2000.02.01. | 2000.05.30. | <p>Ноосыг сэгсэрч сэмлэх, эмульсжүүлэх, самнах, туузлах, нарийсган сунгах, ээрэх, давхарлан эрчлэх, ороох дамжлагаар Хивсний зориулалтын ээрмэл үйлдвэрлэх аргын ялгаа нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, нэр төрлийг олшруулах зорилгоор эмульсжүүлэгчээр 2%-н остендаль EW, 3%-н антистатик ОС-20, 95%-н усны найрлагатай бодисыг сонгож кардолентийн зүүний тоог ерөнхий хүрд болон ажлын 1, 2, 3 дугаар голуудад I самналтад 28/32-26/30, II самналтад 22-26 байхаар мөн нарийн зүүт самналтын зүүний тоог хоёр нэгжээр өндөрсгөн тохируулсан.</p> <p>Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь далавчит ээрэх машины хурдыг 5м/мин-ээр хурдасган туузлах машины сунгах механизм ба самт гадаргуу хоорондын зайг дамжлага тус бүр дээр I, II-35, III-45, IV-33, V-37мм байхаар тохируулаад 6-7кгх/см² ачаалалтай самнаж туузлана.</p> |
| 37. | 1683 | “Супер” хивс нэхэх арга | Г.Надмид Д.Мөнхжаргал А.Батсайхан | 6 D 04 G 03/04, D 03 D27/06 | Г.Надмид Д.Мөнхжаргал А.Батсайхан | 2000.02.01. | 2000.05.30. | <p>1.Карт цоолох, хөндлөн ба дэвсгэр суурь утас ороох, нэхэх, хяргах, нөхөн засах, цардах, огтлох, захлах дамжлагаар “Супер” хивс үйлдвэрлэх аргын ялгаа нь хивсний чанарыг сайжруулах, ээрмэлийн орцыг хэмнэх зорилгоор үслэг суурь утсанд шугаман нягт 211.5 текс, вариацийн коэф. 6.9%, 1м дэх эрчийн тоо 175, эрчийн вариацийн коэф. 5.4%, даац 8.03гх/текс, суналт 8.98% үзүүлэлттэй ээрмэлийг сонгосон.</p> <p>2. Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь хивс цардах бодисоор 12кг амитекс, 24кг превоцелл А-АВ, 400л усны найрлагатай хольцыг хэрэглэнэ.</p> <p>3. Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь үндсэн ба дэвсгэр утасны ангайлтын дотор талд үслэг суурь утасны битүү гогцоо үүсгэж, түүний хоорондуур нь хөндлөн утас оруулан сүлжиж хээ хуарыг шинээр боловсруулсан программаар гаргана.</p> |

| | | | | | | | | |
|-----|------|------------------------------------|--------------------------------------|---|--------------------------------------|-------------|-------------|--|
| 38. | 1685 | Эсгий эд хийх арга | Б.Эрдэнэцэцэг | 6 D 04 H1/10 | Б.Эрдэнэцэцэг | 1999.12.09. | 2000.05.30. | <ol style="list-style-type: none"> 1. Ноосны эсгийрэх чадварыг ашиглан Эсгий эд хийх аргын ялгаа нь жижиг эсгий эд хийх зорилгоор биетийн 3 хэмжээсийн харьцаагаар гажих үзэгдэлд тулгуурлан зулж нягтруулсан ноосон эдлэлийн бие даасан дүрс гаргаж үйлдвэрлэнэ. 2. Эсгий эд хийх аргын ялгаа нь хавтгай дүрсийн эд хийхэд самнасан ноосыг уртааш, хөндлөөш нь туухайлан зулж, шавшаад, модон өнхрүүшэд ороож, ус нэвчих эдээр ороож өнхрүүшдэн, бүлээн усанд сойж чангаруулж нягтруулна. 3. Эсгий эд хийх аргын ялгаа нь эзлэхүүний дүрс гаргахдаа, хэвний гаднаас, самнасан ноосыг босоогоор зулж ороогоод 40-45 хэмийн усаар шавшиж, хоёр талаар нь эргүүлж шавхарч, ус нэвчих эдээр боож элдүүрдээд, бүлээн усанд сойж чангаруулж нягтруулна. 4. Эсгий эд хийх аргын ялгаа нь бөмбөлөг буюу уртааш дүрсийн эдийг үүсгэхэд самнасан ноосыг норгож, бөмбөлөг байдлаар алган дотроо буюу уртааш нь цувьж алгадаж нягтруулна. 5. Эсгий эд хийх аргын ялгаа нь бэлэн зулхайг савангийн уусмалаар өнгөлж, шаардлагатай өнгө, чимэглэл, хээ гаргаж зулж өнхрүүшдэн 40-50 хэмийн бүлээн усанд сойж нягтруулна. |
| 39. | 1688 | Мөнгө жүүлсэн архи үлдвэрлэх шугам | Ч.Авдай Б.Сүрэнхор С.Ганбаатар | С 12 Н 01/16, 6 С 12 F 1/08, В 01 D 3/00, С 12 G 3/12 | Ч.Авдай Б.Сүрэнхор С.Ганбаатар | 1999.11.09. | 2000.06.27. | Ус зөөлрүүлэгч, шахуурга, холих ган, барилтын сав, нүүрсэн болон элсэн шүүлтүүр, савлах төхөөрөмжөөс бүрдэх Мөнгөжүүлсэн архи үйлдвэрлэх шугамын ялгаа нь хийцийг боловсронгуй болгож цэвэршилтийг сайжруулах, архины найрлагад мөнгөний ион шингээх зорилгоор ус зөөлрүүлэх төхөөрөмжийн дараа мөнгөжүүлэх анхдагч аппаратыг найруулах гангийн өмнө спирт дахин нэрэх төхөөрөмжийг, барилтын сав ба хадан цагаан шүүлтүүрийн завсарт цеолитэн шүүлтүүрийг, элсэн шүүлтүүр ба бэлэн бүтээгдэхүүн савлах төхөөрөмжийн хооронд архи мөнгөжүүлэгч нэмэлт төхөөрөмжийг тус тус угсарч зохиомжилсонд оршино. |

| | | | | | | | | |
|-----|------|---|---|---------------------------------|---|-------------|--------------|--|
| 40. | 1691 | Энгийн найрлагатай тэсрэх бодис | Б.Лайхансүрэн Д.Тэгшээ А.А.Лисенко Н.Г.Корохка Х.Бадамсүрэн Ю.А.Чертков В.А.Тюрин | 6 С 06 В 23/00-47/14 | Б.ЛайхансүрэнД. Тэгшээ А.А.Лисенко Н.Г.Корохка Х.Бадамсүрэн Ю.А.Чертков В.А.Тюрин | 2000.02.09. | 2000.06.27. | Аммиакийн шүү, дизелийн түлш, нүүрсний нунтаг, хөнгөн цагаан хольцоос бүрдэх энгийн найрлагатай тэсрэх бодисын ялгаа нь тэсрэлтийн хүчийн нэмэгдүүлэр зорилгоор 1000 грамм бодисын найрлагад аммиакийн шүү 885-915гр, дизелийн түлш 25-36гр, хөнгөн цагааны нунтаг 45-56гр, нүүрсний нунтаг 15-18гр хэмжээгээр хольж бэлтгэнэ. |
| 41. | 1742 | Чулуун нүүрснээс утаагүй бүхэл түлш бэлтгэх арга | Г.Бадамхатан | . | Г.Бадамхатан | 2000.07.31. | 2000.12.11. | 1. Чулуун нүүрсийг ангилан ялгаж үеийг нь шатааж битүү халаах үйлдлээр чулуун нүүрснээс утаагүй бүхэл түлш бэлтгэх аргын ялгаа нь ахуйн аргаар бат бэх чанартай түлш гаргах зорилгоор 25-50мм буюу 50-100мм бүхэлтэй чулуун нүүрсийг жижиг эзлэхүүнтэй тоосгон бааюунд дүүргэж битүүмжлээд, дээрээс нь 15см үеийг 22-24 цаг уугуулж шатаагаад, доорхи үеийг нь төөнөн хагас коксжуулна. 2. Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь ангилан ялгасан нүүрсний бүхлийн хамгийн бага ба томын ширхэглэлийн хэмжээний зөрүү хоёр дахинаас бага байна. |
| 42. | 1743 | Чулуун ба хатуу хүрэн нүүрснээс шахмал түлш үйлдвэрлэх арга | Г.Бадамхатан | . | Г.Бадамхатан | 2000.07.31. | 2000.12.11.3 | Нүүрсийг шигших, шавар, устай холих, нунтаглах, амраах, шатаах, хатаах замаар шахмал түлш үйлдвэрлэх аргын ялгаа нь илчлэгийг дээшлүүлэх, үнслэгийг бууруулах, гүйцэд шаталтыг хангах зорилгоор 20мм-ээс бага ширхэглэлтэй чулуун ба хатуу хүрэн нүүрсийг шар шавартай жингийн 90:10 харьцаагаар хольж, жингийн 4-4.5 хувийн усаар зуурч, 3мм болтол нунтаглаад, 2 цагаас багагүй амрааж, шахаж хатаана. |
| 43. | 1744 | Шахмал түлш бэлтгэх арга | Г.Бадамхатан | 6 С07 С 401/04, А 61 К31/415 | Г.Бадамхатан | 2000.07.31. | 2000.12.11. | 1. Шахмал түлш бэлтгэх аргын ялгаа нь 0-6мм болтол нунтагласан нүүрс, эсвэл модны үртэс, аргалыг жингийн дараахь харьцаагаар хольж усаар зуурч нягтруулаад 10кг/см ² даралтаар шахаж хатаана. а. Нүүрс-аргалын хольц /%/, нүүрс-70, нойтон аргал-30, ус-2.5-3.0 жингээс б. Үртэс арглаын хольц /%/, үртэс-70, аргал-30, ус-3.0-4.0 жингээс 2. Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь холбогч материалаар, малын ялгадсаас гаргасан био, хийн үлдэгдэл заармагийг 30% хүртэл орцтойгоор ашиглаж болно. |

| | | | | | | | | |
|-----|------|--|--|---|--|-------------|-------------|--|
| 44. | 1765 | Спиртийг дахин нэрэх арга | Ч.Авдай Б.Сүрэнхор С.Ганбаатар | С 12 G 3/12, 6 С 12 F 1/08, B 01 D 3/04 | Ч.Авдай Б.Сүрэнхор С.Ганбаатар | 2000.02.17. | 2001.03.06. | 1. Спирт дахин нэрэх аргын ялгаа нь спиртэнд агуулагдах хорт нэгдлүүдийн хэмжээг багасгах зорилгоор уг төхөөрөмжийн босоо хоолойн тавагнуудын хооронд аюулгүйн шилэн үртэс хийнэ. 2. Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь аюулгүйн шилний үртэсний хэмжээ 5см-ээс илүү урт, өргөнтэй байна. |
| 45. | 1780 | Шөрмөсөөр утас хийх технологийн горим | С.Төгс | A 61 B 17/00, A 61 L 17/00 | С.Төгс | 2001.01.16. | 2001.06.28. | Түүхий эдийг бэлдэх, давстай уусмалаар боловсруулалт хийн хатаах, хальслах, нүдэх, эрчлэх үйлдлүүдээр шөрмөсөн утас хийх ялгаа нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилгоор дараахь хүснэгтэнд харуулсан дэс дараалсан үйл ажиллагаагаар бүтээгдэхүүнийг бэлэн болгоно. |
| 46. | 1840 | Тэмээний ноосыг хуурай боловсруулах арга | Л.Гонгор Д.Ганболд Г.Надмид Н.Энхтуяа | 6 D 01 B 3/00 | Л.Гонгор Д.Ганболд Г.Надмид Н.Энхтуяа | 2001.01.16. | 2001.06.28. | Цэвэрлэх, дэвсэх, холих, сэгсрэх замаар Тэмээний ноосыг хуурай боловсруулах аргын ялгаа нь цэвэрлэсэн ноосонд каолиныг жингийн 1:0.4 харьцаагаар хольж, 22 ⁰ С хэмд 32 цаг хэвтүүлээд, сэгсэрч ноосноос тосыг салгана. |
| 47. | 1933 | Монгол адууны сүүлний хялгасан ээрмэл | Б.Болормаа Р.Бавуудорж Б.Баярбат | D 02 G3/04 | Б.Болормаа Р.Бавуудорж Б.Баярбат | 2001.10.01. | 2002.03.06. | Хялгас, голч утас, хөвөн утас агуулах Монгол адууны сүүлний хялгасан ээрмэлийн ялгаа нь 100мкм-ээс дээш голчтой, 30см-ээс богиногүй урттай хялгасыг дангаар нь эсвэл голч утастай давхарлан, хөвөн утастай 1:1 харьцаагаар авч, 10см-д 36-аас цөөнгүй ороодос ноогдохоор ээрнэ. |

| | | | | | | | | |
|-----|------|---------------------------------|--|---------------|--|-------------|-------------|--|
| 48. | 1947 | Ээрмэл үйлдвэрлэх арга | Б.Болормаа Р.Бавуудорж Б.Баярбат | 7 D 02 G 3/04 | Б.Болормаа Р.Бавуудорж Б.Баярбат | 2001.10.01. | 2002.03.06. | Ээрэх, ороох, бүрэх үйлдлээр Ээрмэл үйлдвэрлэх аргын ялгаа нь цэвэрлэж бэлтгэсэн адууны сүүлний хялгасыг 96.6м/мин хурдтай ээрүүлгүй ээрэх машины тэжээх сувгийн дагуу нэг нэгээр нь голч утсыг дагуулан тасралтгүй тэжээж, машины чиглүүлэгчийн эргэлдэх хөдөлгөөнөөр гадуур нь 30/2, 56, 6/1 номерийн хөвөн голч бүрэх утастай дангаар нь эсвэл давхарлан ороож, дахин эсрэг чиглэлд нь бүрнэ. |
| 49. | 1998 | Чацаргана тай ааруул | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 7A23E9/113 | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 2002.04.08. | 2002.09.11 | Аарц, элсэн чихэр агуулах Чацарганатай ааруулын ялгаа нь найрлагад нь тослог багатай аарц, чацарганы уураг, элсэн чихэр, ургамлын тосыг 10:1.5:2.0:0.005 харьцаагаар холино. |
| 50. | 2010 | Чацарганы хуурай ханд | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 7A 23L 1/06 | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 2002.04.08. | 2002.09.12. | Элсэн чихэр, чацаргана агуулах Чацарганатай хуурай хандны ялгаа нь урьдчилан бэлтгэсэн арвай буудай, чацарганы өтгөн шүүс, элсэн чихрийг 1.0:1.0:1.0 харьцаагаар холино. |
| 51. | 2012 | Борцтой хуурай шөл бэлтгэх арга | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 7A 23 L 1/36 | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 2002.04.08. | 2002.09.12. | 1. Угаах, хатаах, буцалгах, нунтаглах үйлдлээр Борцтой хуурай шөл бэлтгэх аргын ялгаа нь угаах хатаасан 1.0 кг арвайг урьдчилан амталж бэлтгэсэн үхрийн ясны тунгаасан 1л шөлөнд хийж, 70-100°C хэмд буцалган загсааж, хатаагаад нунтаглана. 2. Томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь шөлийг 2л усанд 0.5кг жижиглэсэн үхрийн сээр, нуруу, хавирганы яс, 2ш лаврын навч, 2ш даалиу, 3ш хаожу, 30гр үхрийн борц, 2 хумс сармис, 20гр давс нэмж, 1л болтол нь буцалгаж бэлтгэнэ. |

| | | | | | | | | |
|-----|------|---|---|----------------|---|-------------|-------------|--|
| 52. | 2015 | Чацаргана тай шимийн архи үйлдвэрлэх арга | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 7 С 12 G 3/06 | Ч.Авдай С.Чулуун И.Базаррагчаа Б.Сүрэнхор Ч.Наран Ч.Саран | 2002.04.08. | 2002.09.12. | Нэрэх, холих, амраах, шүүх үйлдлээр Чацарганатай шимийн архи үйлдвэрлэх аргын ялгаа нь шүүсэн 60° чангатай 90л шимийн архинд 100л зөөлрүүлсэн ус, 10л чацарганы тунгалаг шүүс нэмж, 2 цаг амрааж, цеолит-элс-хадан цагаан –идэвхжүүлсэн нүүрсээр дамжуулан шүүгээд бүхэл жимс нэмнэ. |
| 53. | 2018 | Цийдмэг тэсрэх бодис | Б.Лайхансүрэн Ю.А.Чертков Н.Бямбадорж И.Л.Бушев Д.Нямдорж Ю.Н.Васель ченко С.Ганжаргал | 7 С 06 В 23/00 | Б.Лайхансүрэн Ю.А.Чертков Н.Бямбадорж И.Л.Бушев Д.Нямдорж Ю.Н.Васель ченко С.Ганжаргал | 2002.03.12 | 2002.09.12. | Цийдмэг-тэсрэх бодисын ялгаа нь цийдмэг тэсрэх бодисын тосон фазын суурь, дизелийн түлш (C ₁₆ H ₃₂)-4.6%, лааны тос (C ₂₄ H ₅₀)-2.0%, эмульгатор (C ₂₄ H ₄₄ O ₆)-1.2% дээр уусмалын фазын найрлагыг өөрчлөн аммиакийн шүү (NH ₄ NO ₃)-70%, натрийн шүү (NaNO ₃)-7%, карбамид (CO(NH) ₂) ₂ -3%, ус (H ₂ O)-149-иар найруулна. |
| 54. | 2022 | Ургамлын будагт ханд бэлтгэх арга | М.Тамара Г.Надмид С.Цэрэндулам А.Гарамжав | 7D 06 P 7/10 | М.Тамара Г.Надмид С.Цэрэндулам А.Гарамжав | 2002.03.27. | 2002.09.12. | 1. Будагт ургамал түүх, бэлдэх, устай холих, хандлах, хөргөх, шүүх үйлдлээр Ургамлын будагт ханд бэлтгэх аргын ялгаа нь будагт ургамлын 0.1мм хэмжээтэй дээжийг устай 1:10 харьцаагаар авч, хэт авианы үйлчлэлтэй, эсвэл үйлчлүүлэхгүйгээр, 70°С хэмд 60мин хандалж, 20-22°С хэмд хөргөж, шүүж хадгална. 2. Ургамлын будагт ханд бэлтгэх аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь будагт ургамал нь долгионтсон гишүүнэ, зүрхэн ягаандай, сэгсгэр яргуйжин, эгэл өмхий өвс, олслог халгай зэргээс сонгогдсон байна. |

| | | | | | | | | |
|-----|------|---|--|---------------|--|-------------|-------------|---|
| 55. | 2023 | Ноос ноолуурыг ургамлын будгаар будах арга | Г.Надмид С.Цэрэндулам А.Гарамжав М.Тамара | 7 D 06 P 7/10 | Г.Надмид С.Цэрэндулам А.Гарамжав М.Тамара | 2002.03.27. | 2002.09.12. | <p>1. Будагт ургамал сонох, уусмал бэлдэх, халаах, будах, хөргөх, бэхжүүлэх, зайлах үйлдлээр Ноос ноолуурыг ургамлын будгаар будах аргын ялгаа нь будагт ургамлын хандыг устай 1:10 харьцаагаар хольж, 5-10%-н бэхжүүлэгч уусмал нэмж, хэт авианы үйлчлэлтэй, эсвэл үйлчлүүлэхгүйгээр, 70°C хэмд 20 минут халааж орчны рН, хандшил, бэхжүүлэгчийн төрлөөр тохируулан олон өнгө үүсгэн будаад, 20-22°C хэмд хөргөж, хүйтэн усаар зайлж, 1%-н цууны хүчлийн уусмалд 15 минут байлгаж, зайлж хатаана.</p> <p>2.Ноос, ноолуурыг ургамлын будгаар будах аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь будагт ургамал нь долгионтсон гишүүнэ, зүрхэн ягаандай, сэгсгэр яргуйжин, эгэл өмхий өвс, олслог халгай зэргээс сонгогдсон байна.</p> |
| 56. | 2026 | Ноолууран эдлэлийн орчиндоо тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх плазмын арга | Ш.Саранчимэг | 7 H 05 H 1/24 | Ш.Саранчимэг | 2002.04.08. | 2002.09.12. | Ноолууран нэхмэл материалыг агаарын орчинд 23 секундын хугацаанд 700мА гүйдлийн хүчээр, 140Па плазм үүсгэх хийх даралтын чадалтай уугих дараагийн боловсруулалтаар бага агшилттай, эдэлгээнд найдваршилтай, тэсвэртэй болгох Ноолууран эдлэлийн орчиндоо тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх плазмын аргыг боловсруулсан. |
| 57. | 2058 | Богийн гүзээ хэрхнэг боловсруулах арга | Б.Энхтуяа Ж.Оюунтүлхүүр Д.Сувдаа | 7 C 14 C 9/02 | Б.Энхтуяа Ж.Оюун түлхүүр Д.Сувдаа | 2002.06.26. | 2002.11.30 | Угаах, гандах, идээлэх, тослох, дүүргэх замаар Богийн гүзээ, хэрхнэг боловсруулах аргын ялгаа нь өнгөн хөрсий нь хуулсан богийн гүзээ, хэрхнэгийн холбох эдэд, 60-100г/л хоолны давс, 2-6г/л цууны хүчлийн 20-22°C хэмийн уусмалыг 14-20 цаг нэвчүүлж, шар хальсыг хуулж, түүхий эдийн жингийн 2 хувьтай тэнцэх хромын исэлтэй идээлгийн шимийг нэвчих уусмалын 80 хувьд нэмээд, 20-25°C хэмд 10-16 цаг идээлж, 0.5-3.0г/л ОП-10 агуулах 60-65°C хэмийн шимэд тосыг салгаж, 50-65°C хэмтэй уусмалд угааж, будаад, мөн хэмтэй шимд тосолгоо, дүүргэлт хийгээд бэхжүүлж, чийг, тослог, суналт, зузаан багатай ус даах чадвартай бүтээгдэхүүн гаргана. |

| | | | | | | | | |
|-----|------|---|-----------------------------------|----------------|-------------------------------|-------------|-------------|---|
| 58. | 2079 | Ахуйн хэрэглээний шаазан, вааран эдлэл үйлдвэрлэх жор ба арга | Ц.Жадамбаа Ж.Тэмүүжин | 7 С 04 В 33/00 | Ц.Жадамбаа Ж.Тэмүүжин | 2002.08.09. | 2002.12.24. | <p>1. Нунтаглах, холих, зутагнах, талхлах, хэвлэх, шатаах, хөргөх, талстжуулах, хөргөх, засварлах, чимхэх замаар Ахуйн хэрэглээний шаазан, вааран эдлэл үйлдвэрлэх жор ба аргын ялгаа нь агаарын хуурай байдалтай 0.4мм-ээс доош нунтаг цонхны шил, 30%-иас их Al_2O_3, 0.5%-иас бага Fe_2O_3 агуулсан, 1мм-ээс дүүш буталсан каолин, 1мм-ээсбага ширхэглэлтэй хайлуур жоншийг шингэн шил, устай 55-60%-ийн чийглэгтэй зутан үүсэхээр жингийн дараахь харьцаатай хольцыг тээрмийн эзлэхүүний 80-90%-д хольц: талхлах үрэл:ус=1:1, 5:1.2 гэсэн харьцаагаар хийнэ. /жингийн %/</p> <p>Каолин 50-65, хаягдал шил 25-50, хайлуур жонш 3-10, шингэн шил 1-3</p> <p>2. Ахуйн хэрэглээний шаазан, вааран эдлэл үйлдвэрлэх жор ба аргын ялгаа нь үүссэн зутанг 7-8 цаг талхлаад, шүүж, холимогийн нягт 1.56-1.58г/см³ болоход хэвэнд цутгаж 30-40 минутын дараа хэвнээс сулалж усыг шүүрүүлээд тасалгааны хэмд 24 цаг байлгаад засч, пааландаад, 100°C хэмд 1-2 цаг шатааж, 800-850°C хэмд 3-5 цаг бариулж, талстжуулаад, зуухандаа 16-24 цаг тавьж хөргөнө.</p> |
| 59. | 2100 | Дулаалгын хялгасан цаваг | Ч.Алтанцэцэг П.Булга М.Баяр | - | ШУТИС-ийн хувцас судлалын төв | 2002.09.02. | 2003.02.18. | Дулаалгын хялгасан цавагны ялгаа нь хонь, тэмээ, ямааны ноосны сул ширхэгт хялгасыг 1.5м өргөнөөр, 35-70мм зузаан зулхайлж бөс материалд хавчуулж, 7-8см зайтайгаар ширнэ. |
| 60. | 2104 | Хатуу биетийг ялгах төхөөрөмж | Л.Пүрэв Д.Сүрмаажав | 7 В 07 В 1/00 | Л.Пүрэв Д.Сүрмаажав | 2002.10.02. | 2003.02.18. | Шигшүүр, тулгуур, өргөгч, тэнцвэржүүлэгч, хаалт, ачилтын хоолой, утсан татуургат удирдлагаас бүрдэх Хатуу биетийг ялгах төхөөрөмжийн ялгаа нь давхар ёроолтой 30мм-ээс ихгүй шүршүүртэй тосгуур-гулсуурыг хаалт, хөдөлгөх удирдлагаар тоногдсон хос хоолойд салаалж, хөдөлгөөнгүй болон өргөгч тулгуур дээр суурилуулж, ачилтын чиглэлд хатуу биетийн жингээрээ гулсах чанараар нь түүний нурах налуугийн өнцөгт хүртэл хазайлгах хөдөлгөөнт тулгуураар тулж, ачилтын эсрэг талд тэнцвэржүүлэгч уяж өгнө. |

| | | | | | | | | |
|-----|------|--------------------------|--|--|---|-------------|-------------|--|
| 61. | 2128 | Шир боловсруулах арга | М.Төмөржав Л.Санжаа Б.Энхтуяа | | М.Төмөржав Л.Санжаа Б.Энхтуяа | 2002.11.17. | 2003.03.31. | <p>-Дэвтээх, гандах, тосолж элдэх эсвэл дэвтээх, шохойдох, угааж шохой арилгах, давслах, эгшээгээд тосолж элдэх дамжлагаас бүрдэх Шир боловсруулах аргын ялгаа нь технологийг боловсронгуй болгох зорилгоор анхны дэвтээлгийг 20°C-24°C хэмтэй усанд 2%-ийн гадаргуугийн идэвхит бодисыг жингийн дараахь харьцаагаар нэмж 10-14 цаг дэвтээнэ. Үүнд 100кг шир боловсруулахад; ус 195-200л, гадаргуугийн идэвхэт бодис 4-50кг</p> <p>-Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь рН 3.5-4.0 хүчиллэгтэй шар сүү, сүүн хүчлийн Lactobacillus Plantarum омгийн бооржин, сорбионы хүчил, 4%-ийн натрийн шүлт, хоолны давсыг 35°C-40°C хэмтэй усанд жингийн дараахь харьцаагаар нэмээд түүхий эдийг 8 цаг тутамд 10 минутын турш хутгаж 72 цаг гандаад, эгшээж чийглэгийг 9.6-9.8%-тай болтол тосолж элдэнэ. Үүнд: ус 195-200л</p> <p>шар сүү 98-100л, сүүн хүчлийн Lactobacillus Plantarum омгийн бооржин 2.8-3.0л, сорбионы хүчил 18-204л, 4%-ийн натрийн шүлт 24- 26л, хоолны давс 9.5-10кг</p> <p>-Аргын томъёоллын нэгээс гуравдугаарын ялгаа нь түүхий эдийг дэвтээсний дараа 20°C-22°C хэмтэй усанд 60%-ийн натрийн сульфид, калийн гидроксидыг жингийн дараахь харьцаагаар нэмж 95-96 цаг шохойдоод 0°C-4°C хэмтэй усанд 45-60 минут угаана.</p> <p>ус 300л, 60%-ийн натрийн сульфид 5.5-9.5кг, калийн гидроксид 3.5-6.5кг</p> <p>-Аргын томъёоллын нэгээс гуравдугаарын ялгаа нь ширийг жингийн 1.0-1.5 харьцаагаар 26°C-28°C хэмтэй усанд 5 цаг дэвтээж шохойг арилгаад уг уусмалд түүхий эдийн жингийн 0.03%-иар хүхэрлэг аммони нэмж 4.8-5 цаг давсжуулна.</p> |
| 62. | 2193 | Барьцал дуулагч материал | Б.Намжилдорж Х.Намхай Б.Өлзийбүрэн | | Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн Барилга-Архитектур корпораци | 2003.03.20. | 2003.08.12. | Барьцалдуулагч материалын ялгаа нь механо химийн аргаар идэвхжүүлсэн, дулааны цахилгаан станцийн циклоны үнс 72%, шохойг 24%-р хольж, хагас уст гөлтгөнө 4%-г нэмж, 5000см ² /г хувийн гадаргуутай болтол тээрэмдээд, хуурай жингийн 50%-н устай зуурч, хэвлэж 24 цаг барьж 950°C-хэмд 2+8+2 цагийн горимоор дулааны боловсруулалт хийн нам суурилаг гидросилкат болон гидросульфоалюминат нэгдэл үүсгэнэ. |

| | | | | | | | | |
|-----|------|---|--|----------------|--|-------------|-------------|---|
| 63. | 2225 | Нутгийн омог Saccharomyces oviformus- /Y ₂₀ / | Ч.Авдай П.Одонмажиг П.Цэвэгмэд Б.Дэлгэрмаа Х.Энхжаргал Ц.Рэнцэнханд Д.Цэрэндулам | 7 С 12 N 01/23 | Ч.Авдай П.Одонмажиг П.Цэвэгмэд Б.Дэлгэрмаа Х.Энхжаргал Ц.Рэнцэнханд Д.Цэрэндулам | 2003.06.02. | 2003.10.17. | Үхрийн нүдний жимснээс ялгасан Нутгийн омог Saccharomyces oviformus- /Y ₂₀ / нь бэлгийн бусаар нахиалан үрждэг, нэг уутанцартаа 1-4 бөмбөлөг хэлбэрийн аскоспор агуулж, эс нь 6-8мкм, хөдөлгөөгүй, өндөг хэлбэрийн колони нь 8-9см голчтой, товгор төвтэй, цагаан шаргал өнгөтэй, дугуй хэлбэртэй, ирмэгээрээ тэгш, гилгэр гадаргуутай, дарс исгэхэд ашиглагдана. Уг омог нь “ХҮНСТЕХ” корпорацийн микробиологийн лабораторийн бичил санд хадгалагдаж байна. |
| 64. | 2226 | Нутгийн омог Saccharomyces cerevisiae- Ч | Ч.Авдай П.Одонмажиг П.Цэвэгмэд Б.Дэлгэрмаа Х.Энхжаргал Ц.Рэнцэнханд Д.Цэрэндулам | 7 С 12 N 01/23 | Ч.Авдай П.Одонмажиг П.Цэвэгмэд Б.Дэлгэрмаа Х.Энхжаргал Ц.Рэнцэнханд Д.Цэрэндулам | 2003.06.02. | 2003.10.17. | Чацаргана жимснээс ялгасан Нутгийн омог Saccharomyces cerevisiae-Ч нь бэлгийн бусаар нахиалан үрждэг, нэг уутанцартаа 1-4 бөмбөлөг хэлбэрийн аскоспор агуулж, эс нь 10-12мкм, хөдөлгөөгүй өндөг хэлбэрийн колони нь 7-8см голчтой, товгор төвтэй, цагаан шаргал өнгөтэй, дугуй хэлбэртэй ирмэгээрээ тэгш, гилгэр гадаргуутай, дарс исгэхэд ашиглагдана. Уг омог нь “ХҮНСТЕХ” корпорацийн микробиологийн лабораторийн бичил санд хадгалагдаж байна. |
| 65. | 2230 | Хонины ноосноос ноолуур ялгах арга | Д.Батбаяр Д.Мөнхбат Г.Ёндонсамбуу Д.Энхтуяа | . | Д.Батбаяр Д.Мөнхбат Г.Ёндонсамбуу Д.Энхтуяа | 2003.02.10. | 2003.10.17. | Түүхий эд бэлдэх, ангилах, угаах, самнах, хялгас ялгах замаар 85-95 хувийн харьцангуй чийгтэй, 18-25С хэмтэй орчинд 50%-иас багагүй ноолуурын агууламжтай, 15-17%-ийн чийглэгтэй, 1%-иас бага тослогтой хонины ноосыг, ялгах машины малгай, ерөнхий, хуулах хүрдний хоорондын зайг 0.25мм барьж, тэжээлийн хурд 6.0кг/цаг, ерөнхий хүрдийг 280эрг/мин, хуулах хүрдийг 12эрг/мин, хуулах голыг 1600эрг/мин эргүүлж хялгас ялгах Хонины ноосноос ноолуур ялгах арга боловсруулж 22мкм дундаж голчтой, 55мм дундаж урттай ноолуур гарган авч ноосон бүтээгдэхүүний чанарыг сайжруулна. |
| 66. | 2266 | “Эрдэс” хүнсний нэмэлтийг бэлтгэх арга, түүний жор | Б.Энхтуяа Б.Майзул М.Өлзиймөнх В.Отгонтуяа Б.Мягмарсүрэн | 7 А 23 К 1/75 | Б.Энхтуяа Б.Майзул М.Өлзиймөнх В.Отгонтуяа Б.Мягмарсүрэн | 2003.06.10. | 2003.12.18. | 1. Эрдэс бодис, уураг, амин дэмээр баялаг малын уушиг, дэлүүг жижиглэх, хатаах, нунтаглах үйлдлээр хийгдэх “Эрдэс” хүнсний нэмэлтийг бэлтгэх арга, түүний жорын ялгаа нь 2-3мм хүртэл жижиглэсэн түүхий эдийг 85-80хэмд 20 мин чанаад, хатаагчид 80-90хэмд 30 мин барина. 2. Эрдэс хүнсний нэмэлтийн жорын ялгаа нь 10гр бүтээгдэхүүнд: уушиг эсвэл гүзээ 4.1гр, дэлүү эсвэл сархинаг 4.1гр, лууван 1.64гр, сонгино 0.16гр агуулагдана. |

| | | | | | | | | |
|-----|------|---|--|--------------------------|--|-------------|-------------|---|
| 67. | 2273 | Дулаан тусгаарлагч керамик материал | Б.Намжилдорж Б.Өлзийбүрэн | С 04 В 33/00, С 04В33/32 | Б.Намжилдорж Б.Өлзийбүрэн | 2003.07.29. | 2003.12.18. | <p>1. Нунтаглах, эмульс бэлтгэх, хэвэнд оруулах, шатаах үйлдлийг агуулах дулаан тусгаарлагч керамик материал хийх аргын ялгаа нь шаварлаг окуп 65%, баяжуулсан бентонит 30%, шохой 5% хольж, 70-80хэмтэй усанд нийт хуурай хольцын жингийн 0.15%-ийг хөнгөн цагааны нунтаг байхаар тооцоолон эмульсийг бэлтгэнэ.</p> <p>2. Дулаан тусгаарлагч керамик материал хийх аргын ялгаа нь хольцын хуурай жингийн 55%-тай тэнцэх хэмжээний усаар зуурч хэвэнд цутган, 24 цаг тасалгааны хэмд байлгана.</p> <p>3. Дулаан тусгаарлагч керамик материал хийх аргын ялгаа нь 6-8 цаг 200 хэмд 1 цаг, 500 хэмд 2 цаг, 1000-1050 хэмд 4-6 цаг, 850 хэмийн халуунд 2 цаг барина.</p> |
| 68. | 2287 | Гэрийн тэжээвэр амьтны хоол "Асар-Басар" | Б.Энхтуяа Б.Майзул М.Өлзиймөнх В.Отгонтуяа Б.Мягмарсүрэн | А 23 L 1/36 | Б.Энхтуяа Б.Майзул М.Өлзиймөнх В.Отгонтуяа Б.Мягмарсүрэн | 2003.06.10. | 2004.02.02. | <p>Малын дотор эрхтэн агуулах Амьтны хоолын ялгаа нь найрлагын хувьд 70%-д жижиглэж бэлтгэсэн уушиг, дэлүү, гүзээ, сархинаг, 29% хивэг, 10% халгай байхаар авч, хольж, хэлбэржүүлээд, 80-90°C хэмд 30-40 мин хатаана.</p> |
| 69. | 2309 | Хөөсөн шил гаргаж авах түүхий эдийн хольц | Ц.Жадамбаа П.Нарантуяа | С 03 С 11/00 | Ц.Жадамбаа П.Нарантуяа | 2003.08.26. | 2004.02.13. | <p>Хаягдал шилийг ашиглан АХөөсөн шил гаргаж авах түүхий эдийн хольцын ялгаа нь ногоон, хөх, бор лонхны шил бодон чанамалын шилийг доломиттой эзлэх жингийн дараахь хувиар холино. /жин %/</p> <p>Лонхны шил: Ногоон 25-32%</p> <p>Хөх 14-21%</p> <p>Бор 14-21%</p> <p>Чанамалын ба цонхны шил: өнгөгүй 23-45%</p> <p>Доломит 203%</p> |

| | | | | | | | | |
|-----|------|--|---|---------------|---|-------------|-------------|---|
| 70. | 2351 | Ноолуураас сэв, хялгас ялгах нэмэлт тоноглол | Г.Чимэд-Очир Л.Ёндонсамбуу Т.Намнан | | Г.Чимэд-Очир Л.Ёндонсамбуу Т.Намнан | 2003.03.11. | 2004.04.30. | Уг төхөөрөмж нь урьдчилан самнах хэсгээс гарсан туузыг дахин боловсруулалтаар хялгас агууламжийг нь багасгах, самнах машины хүлээн авах хүрдний доор хаягдалтай хамт унаж байгаа ноолуурыг хогт, хольцноос нь аэродинамик төхөөрөмжийн /конденсор/ тусламжтай ялган буцаан авах, ноолуур ялгах ажиллагааг эрчимжүүлэх гол зорилготой юм. Манай орны ноос ноолууран түүхий эдэд ихээхэн хэмжээний хаг, хогт хольц, тоос шороо агуулагдаж байдагтай холбоотой ажлын машины хүлээн авах хүрдний ажлын гадаргуу их бохирдсон байдаг. Иймд хүрдний гадаргууг цэвэрлэх, нөгөө талаас ажлын гадаргуун доод хэсгийн хамгийн их ноолуур унах бүсэд сорох сетка тавьснаар ноолуурлаг хэсгийг хаягдалтай хамт доош унагалгүй ажлын бүсэд буцаан шилжүүлэх төхөөрөмж тавьсан болно. Завсрын дамжуулах хүрдний хүлээн авах хүрдтэй харьцах хэсгийн эсрэг бүсэд шүдний налуугийн дагуу ажлын гадаргуун тодорхой хэсэгт дээшээ чиглэлтэй агаарын урсгал өгснөөр ширхэгтийг хувийн жингийн зөрүүгээр ялган хөнгөн, ноолуурлаг хэсгийг сеткэн цилиндрийн гадаргууд дамжуулна. Шүдний гадаргууд агаарын урсгалыг шүдний налуугийн дагуу өгсөн явдал нь шүдний угийн хэсэг байгаа ноолуурлаг хэсгийг гадагшлахад хялбар, дөхөм болгож байгаа юм. Өгсөх урсгалын хурдны хэмжээг ноосон ширхэгтийн хөвөх хурдны зөрүүгээс хамааруулан тогтооно. Өгсөх агаарын урсгалын хоолойн төгсгөлд ноолуур хүлээж авах зорилго бүхий цилиндр байрлуулсан бөгөөд энэ нь ноолуурыг дахин сайтар хаг, тоос, шорооноос цэвэрлэнэ. |
| 71. | 2361 | Пигментит ноосыг цайруулах арга | Г.Надмид Х.Соёл-Ундрах | 7D 06 L 3/00 | Г.Надмид Х.Соёл-Ундрах | 2003.10.03. | 2004.05.31. | Тодорхой рН-н орчин бүхий уусмалд байлгах, цэвэр усаар зайлах, устөрөгчийн хэт исэлд тодорхой хугацаанд байлгах үйлдлээр Пигментит ноосыг цайруулах аргын ялгаа нь сарлагийн болон тэмээний ноосыг рН 2.5-3.0 бүхий 60°C хэмд халаасан 10г/л төмрийн сульфатын усан уусмалд хийж 60 минут байлгаад, түүнийг 70°C хэмийн цууны хүчлийн сулавтар шингэрүүлсэн уусмалаар зайлаад, дахин бүлээн усаар зайлж, рН 8.5-9.0 бүхий 75мл/л устөрөгчийн хэт исэл болон 8г/л пиродифосфатын натрийн усан уусмалд 120 минут байлгасны дараа бүлээн усаар 2 удаа зайлна. |
| 72. | 2375 | Цагаан зээрийн арьс боловсруулах арга | Б.Энхтуяа Б.Оюунтуяа Ч.Пүрэвдулам | 6 C 02 F 1/18 | Б.Энхтуяа Б.Оюунтуяа Ч.Пүрэвдулам | 2004.01.29. | 2004.07.07. | Норгох, дэвтээх, угаах, идээлэх, тослох, хэвтүүлэх, сунгах, талхих, элдэх зэрэг үйлдлээр Цагаан зээрийн арьс боловсруулах аргын ялгаа нь давстай 30°C хэмийн усанд арьсаа 30 мин эргүүлж, хромозол 2.6 г/л харьцаагаар нэмсэний дараа 1:1 харьцаатай ус GlS хийж 23.6 цаг амрааж, рН 4.0 болтол шүү нэмээд, арьсаа гаргаж хэвтүүлж, тосолж, хатааж, үртсэнд чийглэж, сунгаж, талхиж, зөөллөж, зүлгэж, сэгсэрч, цэвэрлэж боловсруулна. |

| | | | | | | | | |
|-----|------|----------------------------------|--|----------------|--|-------------|-------------|--|
| 73. | 2376 | Хивснээс хялгасыг зайлуулах арга | А.Батсайхан Х.Баярмаа Д.Мөнхжаргал Ц.Эрдэнэбилэг Д.Энхтуяа | 7 D 06 G 1/00 | А.Батсайхан Х.Баярмаа Д.Мөнхжаргал Ц.Эрдэнэбилэг Д.Энхтуяа | 2003.12.17. | 2004.07.07. | Түүхий хивсийг холбож оёх, нөхөн засах, хяргах, цардах, хатаах, огтлох, захилах үйлдлээр хивсний хялгасыг зайлуулах аргын ялгаа нь ерөнхий хурд, хөндийрүүлэгчийн хоорондын завсрыг 40-43мм, суналтын цэг, зүүн самны хоорондын зайг 28мм байхаар тохируулан, самналтын тоог ноосны бүдүүнд тохируулан өөрчилж, нэхсэн хивсний цардуултай үеийг нэмэлт цардагчаар баяжуулж, 110-150С хэмд 2 атм даралтаар цардаж, 100-150С хэмд 6м/мин хурдаар хөвж хатаана. |
| 74. | 2395 | Экскаваторын шанаганы шүд | Д.Дэлэг Л.Хүчитбаатар | 7 E 02 F 09/28 | Д.Дэлэг | 2004.03.19. | 2004.07.26. | Хайлуулах, цутгах, царцаах үйлдлээр хийх Экскаваторын шанаганы шүдний ялгаа нь элэгдэлд тэсвэртэй композит /хольцын/ ган ялтсыг шүдний ажлын хэсгийн өргөний дагуу уртын хагасын хэмжээнд их биед нь суулгаж цутгана. |
| 75. | 2430 | Цэмбэ үйлдвэрлэх арга | Д.Батбаяр Б.Баярбат И.Цэрэндулам М.Цэцгээ Д.Энхтуяа | 7 D 03 D 25/00 | Д.Батбаяр Б.Баярбат И.Цэрэндулам М.Цэцгээ Д.Энхтуяа | 2004.04.12. | | Цэвэрлэх, нэхэх, холих, угаах, агшаах, сэгсрэх, нойтон үслэх, хатаах, хуурай үслэх, норгох, сэгсрэх, хатаах, шалгах, толгойлох үйлдлээр Цэмбэ үйлдвэрлэх аргын ялгаа нь 80% өнгийн ноос, 12% нарийн ноос, 8% капроны холиотой 5/1 номерийн ээрмэл бэлтгэж, саржа 2/2 нэхээсээр нэхээд, нойтон үслэх дамжлагаар 3 удаа, хуурай үслэх дамжлагаар 3-4 удаа болон Боргоцой үслэх дамжлагаар даавууны өнгөн талыг 2-4 удаа, дотор талыг нэг удаа үслэнэ. |
| 76. | 2437 | Биожорлон | Л.Пүрэв | 7 A 47 K 11/22 | Л.Пүрэв | 2004.04.22. | | Суултуур, агаарын хоолой, холих савар, бариул халаагуур, сэнсэн хөдөлгүүр, агааржуулах хоолой, асаагуураас бүрдэх биожорлонгийн ялгаа нь суурийн дундуур нь гэрийн пийшингийн янданг нэвт гаргасан жорлонгийн ёроолд байрлуулсан хайрцгийг холих савраар тоноглож, жорлонгийн ард цахилгаан сэнстэй халаагуур, агаарын хоолойг угсарч жорлонгийн ам болон ёроолд таг хийж өгнө. |

| | | | | | | | | |
|-----|------|--|---|----------------|---|-------------|-------------|--|
| 77. | 2455 | Монгол гэр | Л.Пүрэв | 7 E 04 H 15/34 | Л.Пүрэв | 2004.08.04. | | <p>Шал, унь, хана, тооно, багана бүрээстэй, олон тасалгаатай монгол гэрийн ялгаа нь үүд болон хойморын чиглэлд сунгаж, өндөрлөж зуувайлгасан дүрстэй, зууван шал, тоонотой, янз бүрийн урттай унь, бөгтөрлөсөн хаалгатай, дотуур цаваг, хөшигтэй, бүрээстэй, дотроо зайтай, олон тасалгаанд хуваагдсан байна.</p> <p>Монгол гэрийн томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь хоёр давхар хаалгыг бөгтөрлөж, босгыг өндөрлөсөн.</p> <p>Монгол гэрийн томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь ханыг нарийн ялуу савхаар сараалжилж, дотор гаднаас нь дулаалга нааж, гаднаас нь шавардаж, дотор талаас нь төмөрлөн, тооныг зууван хэлбэртэй жаазалж, өрхгүй, яндангийн нүхгүй хийнэ.</p> <p>Монгол гэрийн томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь шалыг шахмал хавтангаар хийж, доод талд нь ус үл нэвчих материал нааж, доор нь ууттай элсээр ивүүр тавьж, дээр хулдаас болон хивс дэвсгэр нааж дэвсэнэ.</p> <p>Монгол гэрийн томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь гэрийн дотор гал зуухны, ариун цэврийн усан хангамжийн, амралтын, ажлын өрөө, хэсгүүд байрлуулж, тоноглож, ариун цэвэр, бохирын цэвэрлэгээний тоногоор төхөөрөмжлөгдөнө.</p> |
| 78. | 2485 | Хүдрээс ангижруулсан төмөр гарган авах арга | М.Дэлгэрмаа Ц.Жадамбаа Ж.Гомбосүрэн | 7 C 01 G 29/00 | М.Дэлгэрмаа Ц.Жадамбаа Ж.Гомбосүрэн | 2004.10.25. | 2005.03.09. | Хүдрээс ангижруулсан төмөр гарган авах аргын ялгаа нь давиан тээрэмдэж нунтаглаж баяжуулсан 5-25мм ширхэглэгтэй төмрийн хүдрийг, 0-25мм хүртэл нунтагласан нүүрс, 1-4мм хүртэл нунтагласан шохойн чулуутай хольж, 2 хувийн хазгай зууханд 0.1-0.8эрг/минхурдаар эргүүлж, түүхий эдийг 800-1100°C хэмд хүртэл халааж хайлуулан төмрийг ангижруулан, соронзон ялгагч ашиглана. |
| 79. | 2505 | Карт шалгах электрон төхөөрөмжийн ажиллах арга | Б.Зоригтбаатар Б.Луубаатар Ц.Баатархүү Ү.Цэрмаа О.Бат-Энх | , | Б.Зоригтбаатар Б.Луубаатар Ц.Баатархүү Ү.Цэрмаа О.Бат-Энх | 2004.06.04. | , | Карт шалгах электрон төхөөрөмжийн ажиллах аргын ялгаа нь программчлагдсан микросхемт удирдлагаар ажиллах алхамж мотор, татах бул, опсо-хосыг цуваагаар залгаж, цоолсон картыг алхамт моторт оруулж, эргэгч булаар татаж фото гэрэл тусах фото биетийн завсраар оруулах гэрлийн урсгалаар цоологдсон нүхнүүдийн мэдээллийг программт удирдлагад мэдээлж алдааг шалгана. |
| 80. | 2506 | Нэхэх машины жаккардын карт цоолох төхөөрөмж | Б.Зоригтбаатар Б.Луубаатар Ц.Баатархүү Ү.Цэрмаа | ' | Б.Зоригтбаатар Б.Луубаатар Ц.Баатархүү Ү.Цэрмаа | 2005.06.04. | ' | Нэхэх машины жаккардын карт цоолох төхөөрөмжийн ялгаа нь микроконтроллер бүхий ерөнхий удирдлагын блокод карт цоолох, шилжүүлэх нударгат механизмын тэжээлийг залгах реле болон карт цоолох зүүний механизмыг удирдах татах реленүүдтэй блокийг зэрэгцээ холбож, зүүний алхам, дараачийн өгөгдлийг удирдлагын блокод байрлах фото биетийн тусламжаар гүйцэтгэнэ. |

| | | | | | | | | |
|-----|-------------------|--|---|-----------------------|---|-------------|-------------|--|
| 81. | 1371 | Зөөврийн хөргөх чингэлэг | Т.Олзбаатар Ч.Мягмаржав Т.Цогтбаатар Ш.Энх-Амгалан Б.Өсөхбаяр | 6 F 2 J 31/00 | Т.Олзбаатар Ч.Мягмаржав Т.Цогтбаатар Ш.Энх-Амгалан Б.Өсөхбаяр | 1997.10.21. | 1998.07.27. | <p>1. Хөргөх камер ууршуулагч, дулаан солилцуулагч, компрессор, конденсатор, цахилгаан хөдөлгүүрээс бүрдэх Зөөврийн хөргөх чингэлэгийн ялгаа нь овор хэмжээг багасгах зорилгоор модон жаазан хүрээг хуудсан төмрөөр хөндийн үүсгэн өнгөлж, дулаан тусгаарлах хөөсөнцөрөөр дүүргэсэн хавианцаруудад шураг бэхлэх хоног гаргаж, арын хавтанд зэс хоолойнуудыг сүвлэн гадагшлуулах нүх гаргасан.</p> <p>2. Чиглэгийн томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь чингэлэгийг угсрахдаа шалны болон арын хавианг хажуугийн хоёр хавтантай холбож, эцэст нь дээд хавтанг бэхлээд, шургийн хоногийг дулаан тусгаарлагчаар дүүргэж хаалтаар хаана. Хажуугийн хавтанд ууршуулагч, тосгуур, зэс хоолойг урьдчилан бэхлэнэ. Хажуугийн хавтанд тэргэнцэр гүйх ховил гаргасан.</p> |
| 82. | 156 | Айраг бүлэх машин | Д.Хөхөө Твердохлеб Г.В. Л.Мянганбуу | | Твердохлеб Г.В. Д.Хөхөө Л.Мянганбуу | 1979.11.09 | 1979.12.30 | Гар ажиллагааг механикжуулж айргийг үйлдвэрийн аргаар хийх технологийн шугамын гол төхөөрөмж нь болж чадсан. |
| 83. | 662 | Гурилан бүтээгдэхүүн хүүн /боорцог/ бэлтгэх арга | Б.Найгалмаа Д.Цэцгээ Ш.Халтай Д.Энх-Оюун | | Б.Найгалмаа Д.Цэцгээ Ш.Халтай Д.Энх-Оюун | 1990.11.13. | 1992.02.07. | Гурилан бүтээгдэхүүн бэлтгэх аргын ялгаа нь зуурмагийн ус шингээх чадварыг нэмэгдүүлснээр бүтээгдэхүүний гарц нэмэгдэнэ. |
| 84. | Патент 2201703 | Много слойный пакет | Князева Камелия Вениаминовна, Шнеур Юлия Владимировна, Энхцацрал Турболын | 7A41D13/015, 31/02 | Князева Камелия Вениаминовна, Шнеур Юлия Владимировна, Энхцацрал Турболын | 2001.05.23. | 2003.04.10. | Многослойный пакет преимущественно для спецодежды состоит из наружного и внутреннего слоев с размещенной между ними прокладкой, выполненной из уложенных параллельными рядами с интервалами гофрированных элементов, гофры которых расположены перпендикулярно наружному и внутреннему слоям, и связующих элементов шириной, равной ширине основания гофр, соединенных с наружными и внутренними слоями и гофрированными элементами ниточным, клеевым или сварным способом и расположенных параллельно наружному и внутреннему слоям с наружных сторон оснований гофр. Гофры выполнены Z-или -образной формы. Их основания расположены в одну сторону и/или навстречу друг другу, а каждый ряд гофрированных элементов состоит из полос, состыкованных и/или расположенных с интервалами вдоль их ширины с однолинейным расположением интервалов или в шахматном проядке. Связующий элемент выполнен из материала, жесткость которого превышает жесткость материала прокладки, длиной, равной ширине полосы, что повышает ударозащитные и фильтрационные свойства. |

| | | | | | | | | |
|-----|-------------------|--|---|----------------|---|-------------|-------------|--|
| 85. | 2597 | Шилэн керамик гарган авах арга | Ц.Жадамбаа А.Цэцэгмаа Б.Батцэцэг | 7 С 03 С 10/00 | Ц.Жадамбаа А.Цэцэгмаа Б.Батцэцэг | 2005.03.15. | 2005.09.09. | Эх өсгөвөр ба эх материал бэлтгэх, ургамлын гаралтай органик орчин бэлтгэх, суулгац хийх, өсгөвөрлөх үйлдлээр Бактерийн зуурмаг бордоо бэлтгэх аргын ялгаа нь азот шингээгч <i>Azotobacter Chroococcum</i> , фосфорын нэгдлийг задлагч <i>Bacillus circulans</i> бактерийг үржил шимт хөрс, нуур, голын булан тохойн ус, сүү, цагаан идээний шингэн шүүгдсийг хэрчиж жижиглэсэн ургамлын гаралтай холимог органик орчинд суулгац хийж, 25-28 хэмд 3-4 хоног өсгөвөрлөнө. Шилэн керамик гарган авах аргын ялгаа нь хаягдал шил 60-90, каолин 6-40, хайлуур жонш 4-10% бүхий шилэн массаа уян налархай аргаар шахах эсвэл нойтон аргаар цутгаж хэвлээд, хатаасны дараа 1000С хэмд 1 цаг бариулан шатаагаад, 800-850С хэм хүртэл бууруулж 2-5 цаг талсжуулаад тасалгааны хэм хүртэл хөргөнө. |
| 86. | 2512 | Энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх машин “УУХ-1” | Б.Лайхансүрэн Д.Батжаргал Г.Бямбаа Л.Батцэцэг | 7 С 6 В 21/00 | Б.Лайхансүрэн Д.Батжаргал Г.Бямбаа Л.Батцэцэг | 2004.12.02. | 2005.05.02. | Гэр, суурь, хөдөлгүүр, саалтуур, юүлүүр, холигч, шигшүүр бүхий энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх машин “УУХ-1”-ийн ялгаа нь суурь дээр байрласан гэрний ёроолд суурилуулсан цахилгаан хөдөлгүүртэй саалтуураас цөнгөөр холбосон босоо гол нэвтрэх, холих тогоонд далавчит хутгуур, бутлах, сийрүүлэх тогоонд шигшүүр, хутгатай шүүр угсарч, хананд нь хутга зоож, холих тогооны бөөрөнд юүлэх цорго, шингэн хольц тургих хошуу угсарч, гэрний дээд амсарыг юүлүүрээр таглана. |
| 87. | 2600 | Энгийн найрлагатай тэсрэх бодис “ЭНТБ-Р” | Б.Лайхансүрэн Ж.Жамъян Т.Самбасанчир | 7 С 06 В 23/00 | Б.Лайхансүрэн Ж.Жамъян Т.Самбасанчир | 2005.05.10. | 2005.09.09. | Энгийн найрлагатай тэсрэх бодис “ЭНТБ-Р”-ын ялгаа нь 1000 грамм бүтээгдэхүүнд дизелийн түлш (C16H3)-50гр, аммиакийн шүү (NH4NO3)-925гр, фосфорын нунтаг (P ₂ O ₅)-25гр хэмжээгээр найруулна. |
| 88. | Патент 2263877 | Способ взрывания горных пород с включениями мерзлоты | Белин В.А. Трусов А.А. Б.Лайхансүрэн Г.Пүрэвсүрэн Ц.Ариунжаргал | | Белин В.А. Трусов А.А. Б.Лайхансүрэн Г.Пүрэвсүрэн Ц.Ариунжаргал | 2004.07.19. | 2005.11.10. | Линз хэлбэрийн мөнхийн хөлдүү үетэй чулуулгын массивыг бутлах арга. 1. Линз хэлбэрийн мөнхийн хөлдүү үетэй чулуулгын массивт тэсэлгээний ажлыг явуулахдаа үндсэн босоо цооногуудын зэрэгцээ тэдгээрийн хооронд нэмэгдэл богино цооногийг хөлдүү үеийн ул хүртлэх гүнд өрөмдөнө. 2. Хөлдүү үед өрөмдсөн үндсэн нэмэгдэл богино цооногт орох тэсрэх бодисын цэнэгийн жин, урт хөлдүү үеийн ул таазанд хийх түгжээсний гүн зэргийг тодорхойлно. |

| | | | | | | | | |
|-----|------|---|--|------------------|--|-------------|-------------|---|
| 89. | 2579 | Барьцалдуул агч материал | Б.Намжилдорж Б.Өлзийбүрэн Д.Чулуунцэцэг | 7 С 04 В 9/00 | Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн Барилга- Архитектур корпораци | 2005.03.23. | 2005.09.09. | 30-50 хувийн шаварын холимогтой гөлтгөний чулууг 100мм-ээс ихгүй хэмжээтэй буталж 600-800С хэмд 6-8 цаг шатааж, 3000см ² /гр хувийн гадаргуутай болтол нунтаглаж, жингийн 3%-д идэвхжүүлэх нэмэлт хийн, 70%-иас дээш идэвхтэй шохойтой 97:3 хувийн харьцаатайгаар хольж 0.3г/л SO ₄ ионы агуулгатай усаар зуурч барьцалдуулагч материал гаргана. |
| 90. | 1303 | Хялгас ялгах төхөөрөмж | Б.Алтаниуяа Д.Энхтуяа | - | Б.Алтаниуяа Д.Энхтуяа | 1997.07.08. | 1997.12.25. | Хялгас ялгах төхөөрөмжийн ялгаа нь ноолуур дахь хялгасны гарцыг багасгах зорилгоор хольцыг олон эгнээт ангилуураар 1-8.7м/сек хурдтайгаар агаараар үлээлгэн хялгасыг суулгаж ялгана. |
| 91. | 2193 | Баоьцалдуул агч материал | Б.Намжилдорж Х.Намхай Б.Өлзийбүрэн | 7 С 04 В 37/00 | Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн Барилга- Архитектур корпораци | 2003.03.20. | 2003.08.12. | Баоьцалдуулагч материалын ялгаа нь механо химийн аргаар идэвхжүүлсэн, дулааны цахилгаан станцын циклоны үнс 72%, шрхрийг 24%-иар хольж, хагас уст гөлтгөнө 4%-ийг нэмж 5000см ² /г хувийн гадаргуутай болтол тээрэмдээд хуурай жингийн 50%-ийн устай зуурч, хэвлэж 24 цаг барьж 95 ⁰ С 2+8+2 цагийн горимоор дулааны боловсруулалт хийж, нам суурилаг гидросилкат болон гидросульфоалюминат нэгдэл үүсгэнэ. |
| 92. | 2131 | Хоол боловсруулах эрхтэний өвчнийг илааршуулан өвчтөнийг сувилах хоол түүнийг хэрэглэх дэглэм | М.Пүрэвжав, Д.Амарбаясгала н, Б.Мэндбаяр, С.Наранцэцэг, Ц.Батсүх, Г.Гомбо | 7 А 23 L 1/29 | М.Пүрэвжав, Д.Амарбаясгала н, Б.Мэндбаяр, С.Наранцэцэг, Ц.Батсүх, Г.Гомбо | 2002.08.21. | 2003.04.24. | Нэг удаагийн хооллолтоор 80-450г тэжээл авч, өдрийн нийт илчлэгийн 3-32 хувийн авна. |
| 93. | 534 | Зуурмагийн хатуу хольцийг ялгах бүтээц | Д.Дэлэг Г.Батсайхан А.В.Туренко Ж.Ринчин Ө.Энэбиш | | Д.Дэлэг Г.Батсайхан А.В.Туренко Ж.Ринчин Ө.Энэбиш | 1990.05.04. | 1990.12.27. | |

| | | | | | | | | |
|-----|------|---|--|-------------------------------------|--|-------------|-------------|--|
| 94. | 535 | Цул материал бутлах бүтэц | Д.Дэлэг Д.Бямбажав Х.Чулуунбаатар | | Д.Дэлэг Д.Бямбажав Х.Чулуунбаатар | 1989.10.26 | 1990.12.27 | |
| 95 | 2811 | Нүүрсний тоосны ширхэгжилт тохируулах ялгагчийн өөрчилсөн хийц ТЭС-2500/900 | П.Даваасүрэн | 7В 02 С 23/10 | П.Даваасүрэн | 2006.05.25. | | Дотоод, гадаад конус, тоос орох гарах хоолой, удирдлагатай хүрзэм бүхий нүүрсний тоосны ширхэгжилт, тохируулах ялгагчийн Нүүрсний тоосны ширхэгжилт тохируулах ялгагчийн өөрчилсөн хийц ТЭС-2500/900-н ялгаа нь гадаад, дотоод конусаас буцах тоосны хоолойг салаалж, гадаад конусын хананд шагайвар гаргаж, ялгагчийн заламгай, хөшгийг $\alpha = 80^\circ$ -т тохируулж, урьдчилан сэргийлэх тэсрэлтийн хавхлага байрлуулж, чиглүүлэх хүрзмийг тоосны холимогийн урсгалтай өнцөг үүсгэн барьж эргүүлэх шаахайгаар холбосон, шингэний хүчлүүртэй тохируулгын удирдах цагаригийг ялгагчийн гарах хоолойд өмсгөн угсаоч, чиглүүлэх хүрзмийг дотоод конусын дээр байрлуулж, тоосны дахин ялгалт үүсгэх боломжтой болгосон. |
| 96 | 2835 | Малын шөрмөсийг бэлтгэх арга | Б.Мягмарсүрэн, Д.Наранчимэг, Н.Өлзийбаяр, Л.Дамдинсүрэн | А 22 С 17/00, А 23 С 21/00, В 26 D, | Б.Мягмарсүрэн, Д.Наранчимэг, Н.Өлзийбаяр, Л.Дамдинсүрэн | 2006.02.27. | 2006.10.25. | Малын шөрмөсийг бэлтгэх, боловсруулах аргын ялгаа нь 24-48 цаг сойж, амраасан малын хойд урд хөлийн шилбэний арьсыг ярж, тагалцагны үеийн орчим хөндлөн зүсэлт хийж, доороос дээш чиглэлээр шилбэний шөрмөсийг зүсч, уртын хэмжээгээр авч болох дээд хэмжээнд хүргэн огтолно. |
| 97 | 2790 | Чацаргана бяцлах төхөөрөмж ГСА-1 | Ч.Авдай, Б.Сүрэнхор, Э.Ганзориг | 7 В 02 С 4/00 | Ч.Авдай, Б.Сүрэнхор, Э.Ганзориг | | 2006.06.25 | Чацаргана бяцлах төхөөрөмж ГСА-1-н ялгаа нь модон тэвшинд бөс даавуугаар ороосон модон голуудыг хосоор нь суулгаж, үзүүрт нь эргэлт дамжуулах бул залгаж, оосороор хөдөлгүүртэй холбож эсрэг эргэлт өгөхөөр зохиомжилсон. |
| 98 | 2792 | Мананжуулах толгой ГСЦА | Ч.Авдай, Б.Сүрэнхор, Э.Ганзориг, С.Цэрэндорж | 7 В 05 В 1/12 | Ч.Авдай, Б.Сүрэнхор, Э.Ганзориг, С.Цэрэндорж | 2006.04.06 | 2006.06.25 | Мананжуулах толгой ГСЦА-н ялгаа нь 6 талт гулузны голоор шулуун хоолойлж нүхлээд, нэг төгсгөлд нь эргэсэн бөглөө хийж, эсрэг үзүүрт нь гадар эргээс гаргаж, тал бүр дээр гаргасан нүхэнд, нэг үзүүрийг нь шовхолж, нумлуулсан саваа төмрийн шовх төгсгөлийн хөндий шургуулж, савааны нөгөө үзүүрийг их биеийн гадарга дээр бэхэлж өгнө. |

| | | | | | | | | |
|-----|------|--|--|------------------|---|-------------|-------------|--|
| 99 | 2667 | Монгол хүний байргын загварчлал | Ц.Нямжав, Ө.Баянтуул, Л.Намсрай найдан | 7 А 47 Н 8/00 | Ц.Нямжав, Ө.Баянтуул, Л.Намсрайнайдан | 2005.10.06. | 2006.02.27. | Олон тооны туршилтын хэмжилтээр монгол хүний биеийн дундаж хэмжээг тогтоож Монгол хүний байргын загварчлал-ыг дараахь хэмжээгээр гаргана. эрэгтэй хүн эмэгтэй хүн мөрийн өндөр 5.0-7.4 4.1-6.5 хүзүүний гүн 7.1-9.5 6.0-8.4 бэлхүүсний I гүн 4.2-6.6 3.3-5.5 бэлхүүсний II гүн 3.7-6.1 4.2-6.6 |
| 100 | 2579 | Барьцалдуул агч материал | Б.Намжилдорж Б.Өлзийбүрэн Д.Чулуунцэцэг | 7 С 04 В 9/00 | Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн Барилга- Архитектур корпораци | 2005.03.23. | 2005.09.09. | 30-50 хувийн шаварын холимогтой гөлтгөний чулууг 100мм-ээс ихгүй хэмжээтэй буталж 600-800С хэмд 6-8 цаг шатааж, 3000см ² /гр хувийн гадаргуутай болтол нунтаглаж, жингийн 3%-д идэвхжүүлэх нэмэлт хийн, 70%-иас дээш идэвхтэй шохойтой 97:3 хувийн харьцаатайгаар хольж 0.3г/л SO ₄ ионы агуулгатай усаар зуурч барьцалдуулагч материал гаргана. |
| 101 | 2171 | Мод хатаах нүхэн хорго | | | | | | |
| 102 | 2177 | Хатаалганы нүхэн хоргоны татлага | | | | | | |
| 103 | 2172 | Хатаалганы нүхэн хоргоор хатаах арга | | | | | | |
| 104 | 2701 | Техникийн эсгий үйлдвэрлэх арга болон хийц | Ц.Дэнсмаа, Д.Лхамсүрэн, Ц.Балжинням, Б.Болдбаатар | D 01H 1/08 | Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн | 2005.07.25 | | |

| | | | | | | | | |
|-----|-------------------|---|---|--------------|---|-------------|-------------|--|
| 105 | 2751 | Хүнсний зэрлэг ургамлаас биологийн идэвхт нэмэлт гарган авах арга | Э.Энхцэцэг | A23 L 1/00 | Э.Энхцэцэг | 2006.02.10. | 2006.04.25. | Хүнсний зэрлэг ургамлаас биологийн идэвхт нэмэлт гарган авах аргын ялгаа нь түүж, сэрүүн нөхцөлд агаарын 75%-иас ихгүй харьцангуй чийглэгт хатаасан ягаан цээнэ, хурган мэхээр, долгионт гишүүнэ, бужгар сараана, одой сараанагийн үндсийг 30-35°C хэмтэй усанд 24-48 цаг дэвтээж, шүүж, 50:50%-ийн ус, үндэсний хольцийг хүйтэн усаар угааж, шүүж, 50-60°C хэмд 10%-иас ихгүй чийглэгтэй болтол хатааж тасалгааны хэмд хөргөнө. |
| 106 | 2752 | Хүнсний ногооны холимгоор хагас бэлэн бүтээгдэхүүн хийх арга | Ө.Гантогоо С.Цэвэл | A 23 L 1/10 | Ө.Гантогоо С.Цэвэл | 2006.03.22. | 2006.04.25. | Хүнсний ногооны холимгоор хагас бэлэн бүтээгдэхүүн хийх аргын ялгаа нь хүнсний ногоог чанараар ялгаж, угааж, хальсалж, цэвэрлэж хэрчээд 130°C хэмийн уураар 0.2-0.4МПа даралтанд 5-10 минут дулааны боловсруулалт хийж, хөргөж, агааргүй нөхцөлд савлаж хөлдөөнө. |
| 107 | 2753 | Гурвалжин будаа үйлдвэрлэх арга | Ө.Гантогоо А.Баяр Ш.Баранчулуун | A 23 L 1/164 | Ө.Гантогоо А.Баяр Ш.Баранчулуун | 2006.03.22 | 2006.04.25 | Гурвалжин будаа үйлдвэрлэх аргын ялгаа нь будааг хольцоноос цэвэрлэж уураар 0.3-0.6МПа даралтанд 6-12 минут боловсруулж, 12-14%-ийн чийгтэй болтол хатааж, хөргөөд хальсалж савлана. |
| 108 | 2738 | Сульфатын орчинд тэсвэртэй цеолитын нэмэлттэй цемент гаргах арга | Д.Сүнжидмаа Б.Батцагаан Т.Цоодол Д.Зориг З.Оюунчимэг | C 04 B 7/30 | Д.Сүнжидмаа Б.Батцагаан Т.Цоодол Д.Зориг З.Оюунчимэг | 2006.02.21. | 2006.03.25 | Портландцементийн чулуунцар нунтаглах явцад түүний жингийн 15-20%-д цеолит нэмж, нунтаглалтын үеийн хувийн гадаргууг нэмэгдүүлж, цементийн физик-механик шинж чанарыг сайжруулсан Сульфатын орчинд тэсвэртэй цеолитын нэмэлттэй цемент гаргах арга боловсруулсан. |
| 109 | Патент 2263877 | Способ взрывания горных пород с включениями мерзлоты | Белин В.А. Трусов А.А. Б.Лайхансүрэн Г.Пүрэвсүрэн Ц.Ариунжаргал | | Белин В.А. Трусов А.А. Б.Лайхансүрэн Г.Пүрэвсүрэн Ц.Ариунжаргал | 2004.07.19. | 2005.11.10. | Линз хэлбэрийн мөнхийн хөлдүү үетэй чулуулгын массивыг бутлах арга. 3. Линз хэлбэрийн мөнхийн хөлдүү үетэй чулуулгын массивт тэсэлгээний ажлыг явуулахдаа үндсэн босоо цооногуудын зэрэгцээ тэдгээрийн хооронд нэмэгдэл богино цооногийг хөлдүү үеийн ул хүртлэх гүнд өрөмдөнө. 4. Хөлдүү үед өрөмдсөн үндсэн нэмэгдэл богино цооногт орох тэсрэх бодисын цэнэгийн жин, урт хөлдүү үеийн ул таазанд хийх түгжээсний гүн зэргийг тодорхойлно. |

| | | | | | | | | |
|-----|------|--|--|------------------|--|-------------|-------------|---|
| 110 | 2890 | Хүрэн нүүрс нэрэх зуух КЗ-45 | Г.Бямбаа /УУХүрээлэн/ | 7С 10 В 3/00 | Г.Бямбаа /УУХүрээлэн/ | 2006.12.21. | | Хүрэн нүүрс нэрэх зуух КЗ-45-ын ялгаа нь металл гадар дотор галд тэсвэртэй материалаар барьсан зууханд усан цамц суурилуулж, галын хотлын хажуу хана, ёроолыг цахилгаанаар халаах элементээр тоноглож, галын хотолд оруулж, гаргах, нүүрс ачаалах салдаг тагтай, бөөрөндөө нүүрс юүлэх битүүмжилсэн тагтай хайрцгийг нүүрс ачих, асгах юүлүүрээр тоноглож өгнө. |
| 111 | 2892 | Органик бодисыг идэвхжүүлэх төхөөрөмж | Г.Бямбаа /УУХүрээлэн/ | 7С 12 Р | Г.Бямбаа /УУХүрээлэн/ | 2006.12.21 | | Органик бодисыг идэвхжүүлэх төхөөрөмжийн ялгаа нь термopapaар тоноглосон цахилгаан залгууртай дулаан үл дамжуулах материалаар хийсэн, гадарга дээр ус буцалгуур бэхлэгдсэн их биеийн дотор цахилгаан халаагууртай битүү тогооны таганд даралтын манометр, илүүдэл хийн хоолой, усны уур оруулах хоолой суулгаж өгнө. |
| 112 | 2935 | Гэрийн зуухны утааг нойтон аргаар шүүх төхөөрөмж | Д.Илчгэрэл У.Ууганбат З.Нурбек | 7F 24 В 1/182 | Д.Илчгэрэл У.Ууганбат З.Нурбек | 2007.02.12 | | Гэрийн зуухны утааг нойтон аргаар шүүх төхөөрөмжийн ялгаа нь зуухны хүхээгт хос хоолой гаргаж, тус бүрт нь хаалт хийж, нэг хоолойд нь салхилуур угсарч, хүхээгний төгсгөлд уртын 2/3-т нь тоосруулагч байрлуулсан охор яндантай усны сав суулгаж, тоосруулагч болон усны савны хоорондох хоолойд шахуурга угсарч өгнө. |
| 113 | 3020 | Торомны ноолуураар сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга | Г.Надмид А.Батсайхан С.Мөнхжаргал Д.Мөнхбат С.Саранцэцэг | D02G3/04 | Г.Надмид А.Батсайхан С.Мөнхжаргал Д.Мөнхбат С.Саранцэцэг | 2007.04.04. | 2007.09.25. | Ангилан ялгах, сэгсрэх, угаах, хатаах, холих, самнах, ээрэх, ороох, эрчлэх, сүлжих, угаах, зөөлрүүлэх үйлдлээр Ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх аргын ялгаа нь дунджаар 16,02мкм голчтой, 48 мм урттай торомны ноолуураар 38,5-38,8 тексийн шугаман нягттай, 199-200эрч/м-ийн эрчтэй, 220-225 гр/тексийн даацтай, ээрмэл бэлтгээд сүлжинэ. Аргын томъёоллын нэгдүгээрийн ялгаа нь 20 зүү босгон анхны эгнээг явуулж, бүр зүүний гому сүлжээгээр дурын хэмжээг авч, урьдчилан гаргасан тооцооны дагуу хормой захыг сүлжинэ. |
| 114 | 3036 | Автомашини тоормосны зам болон удаашралтыг судлах “Деселерограф-МИС” багаж | Ж.Хашбат | G01L5/28 | Ж.Хашбат | 2007.06.15. | 2007.10.25. | ТВ тензо мэдрэгч, INA114AP өсгүүр, HA17358 маягийн 2 өсгүүр, AD7895 хувиргуурын цуваа холбоог инкодер болон тоормосны дөрөөн дээрх мэдрэгчтэй зэрэгцээгээр PIC18F452микро контролёртой холбоод, MAX232 интерфейс болон цахим тооцуурын дохионы порт, цахим тооцууртай цуваа холбож, Автомашини тоормосны зам болон удаашралтыг судлах Деселерограф-МИС” багаж зохиомжилно. |